



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн  
**ӨНӨӨГИЙН БАЙДАЛД**  
хийсэн судалгааны тайлан

---

БРЕНТ Т. УАЙТ  
НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН ЗАХИАЛГААР  
2008 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 18



МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛИЙН  
ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

© Нээлттэй Нийгэм Форум

Энэхүү номын зохиогчийн эрхийг ННФ эзэмших ба судалгааны тайланг хувийн хэрэгцээнээс бусад зорилгоор хэсэгчлэн болон бүтнээр нь хувилж олшруулахыг хүсвэл доорхи хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,  
Утас: 976-11-318207  
Факс: 976-11-324857  
Вэб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

Уг судалгаагаар гаргасан үнэлэлт, дүгнэлт нь Нээлттэй Нийгэм Форумын байр суурийг илэрхийлэхгүй ба уг судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачийн үзэл бодлыг илэрхийлнэ.

DDC  
622.338 1  
ISBN 978-99929-54-79-5

Энэхүү судалгааны тайланг зөвхөн электрон хэлбэрээр хэвлэн нийтэлсэн ба эхийг ВСI хэвлэлийн компанид бэлтгэв.

Улаанбаатар  
2009 он.

# ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ .....	4
ГОЛДОО ХҮРТЭЛ ЯЛЗАРСАН ҮҮ? .....	5
Оршил.....	5
Аргачлал.....	6
Үнэлгээний баг .....	9
МОНГОЛ ДАХЬ ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛИЙН БАЙДЛЫГ ДҮГНЭХ ХҮСНЭГТ .....	10
САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	27
Чанар болон шүүгчийн сургалтад чиглэсэн шинэтгэл.....	27
Шүүхийн нэр хүнд, бие даасан байдалд чиглэсэн шинэтгэл.....	29
Ил тод байдал руу чиглэсэн шинэтгэл.....	30
Хариуцлагын тогтолцоог шинэчлэх талаар.....	31
Авлигаас сэргийлэх тусгай арга хэмжээ .....	32
ХАВСРАЛТ А .....	34
Шүүхийн шинэтгэлийн талаархи санал асуулга.....	34
ХАВСРАЛТ В.....	40
Монгол дахь шүүхийн шинэтгэлийн байдлын талаарх санал асуулгын дүн....	40

# ӨМНӨХ ҮГ

Монгол улсад өрнөсөн ардчилсан шилжилтийн үйл явцын нэн чухал хэсэг нь шүүхийн шинэтгэл юм. Манай оронд сүүлийн 10 жилд хэрэгжсэн шүүхийн шинэтгэлийн үр дүнг үнэлэх зорилгоор Нээлттэй Нийгэм Форумгаас 2008 оны сүүлээр хийсэн судалгааны тайланг танилцуулж байна.

Энэхүү судалгааг АНУ-ын БАР-ын холбооноос боловсруулсан олон улсын хэмжээнд хэрэглэгддэг “Шүүхийн Шинэтгэлийн Индекс”-ийн үзүүлэлтүүдийг манай орны нөхцөлд нийцүүлэн баяжуулж ашиглав. АНУ-ын БАР-ын холбоо үүнтэй ижил төстэй судалгааг Молдав, Узбекистан, Серби, Босни-Герцеговина, Гүрж зэрэг улс оронд хийж байжээ.

АНУ-ын Аризонагийн Их сургуулийн хуулийн профессор Brent Уайт судалгааны тайланг хариуцан бэлтгэлээ. Тэрээр Үндсэн хуулийн эрх зүйгээр мэргэшсэн, судалгаа шинжилгээний ажлын арга зүй эзэмшсэн, шүүхийн практикийг судалж, туршлага хуримтлуулсан профессор юм. Түүний хийсэн энэхүү судалгааны тайлан хийгээд зөвлөмж нь хараат бус, шударга шүүхийг Монгол улсад төлөвшүүлэн хөгжүүлэх үйлсийн төлөө зүтгэж байгаа бодлого боловсруулагчид, шүүхийн байгууллагын ажилтнуудад төдийгүй олон нийтэд чухал ач холбогдолтой хэмээн бид үзэж байна.

Шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах нь дан ганц шүүх эрх мэдлийн хүрээний хэрэг бус юм. Харин Монгол улсын хөгжил, дэвшил, ардчилсан шилжилтийн түлхүүр асуудал учраас олон нийт, иргэний нийгмийн байгууллага, иргэн бүрийн оролцоо, хяналт нэн чухал юм.

Нээлттэй Нийгэм Форум 2008-2010 онуудад Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлээр иргэний нийгмийн байр сууринаас хандан ажиллахаар төлөвлөж, цуврал судалгаа хийж эхэлсний түрүүч нь Уншигч Танд толилуулан буй энэхүү тайлан юм.

Судалгааны тайлан англи хэл дээр бичигдсэн бөгөөд нэр томъёоны болон орчуулгын алдаа мадаг байх аваас бидэнд хандахыг Уншигч Танаас хичээнгүйлэн хүсье.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал  
П.Эрдэнэжаргал

# ГОЛДОО ХҮРТЭЛ ЯЛЗАРСАН УУ?

## ОРШИЛ

1990-ээд оны сүүлчээс эхлэн Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, Германы Техникийн хамтын ажиллагааны Нийгэмлэг, Ханнс Зайделийн Сан, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг зэрэг байгууллагууд хэдэн арван сая долларын хөрөнгийг Монголын шүүхийн “шинэтгэлд” зориулжээ.<sup>1</sup> Эдгээр олон улсын хандивлагч байгууллага, хөгжлийн банкууд ийнхүү шинэтгэлийг дэмжих болсон нь Монголын эдийн засгийг хөгжүүлж, “эрх зүйт ёс”-ыг хэрэгжүүлэх гэсэн үзэл санаанаас үүдэлтэй юм.<sup>2</sup> “Эрх зүйт ёс” нь хэрэг, маргааныг голч, шударгаар, тууштай шийдвэрлэнэ гэсэн олон нийтийн итгэл найдварыг хүлээсэн, зөв ажиллагаа бүхий хараат бус шүүхээс хамаарч байдаг.<sup>3</sup>

Гэвч “шинэтгэл” эхлээд арваад жил өнгөрсөн боловч Монгол Улсын шүүхийн тогтолцоонд итгэх олон нийтийн итгэл маш доод түвшинд байсаар байна. Түүгээр ч үл барам шинэтгэлийн хугацаанд иргэд шүүхийн байгууллагад улам бүр таагүй хандах болж, ялангуяа Улсын Дээд Шүүх болон Үндсэн хуулийн Цэцэд итгэх тэдний итгэл “навс унажээ.”<sup>4</sup>

Саяхан улсын хэмжээнд иргэдийн шүүхэд хандах байдлыг судалж үзэхэд Монголчуудын дөнгөж 28 хувь нь шүүхэд очсон тохиолдолд асуудлаа шударгаар шийдүүлж чадна гэж итгэдэг гэсэн байна.<sup>5</sup> Гэтэл үүний эсрэгээр 85 хувь нь шүүх хөрөнгө чинээ, төрийн албан тушаал, садан төрлийн болон найз нөхдийн холбоо, компани уу, хувь хүн үү гэдгийг харж шийдвэр гаргадаг гэж үзжээ.<sup>6</sup> Мөн үүнтэй адилаар 75 хувь нь шүүхийн шийдвэр улс төрийн нөхцөл байдлыг харгалзан үзэх, шүүгчийн хувийн ашиг сонирхол, төрийн албан тушаалтан зэргийн нөлөөлөлд ордог гэжээ.<sup>7</sup>

---

<sup>1</sup> АНУ-ын ОУХА л гэхэд 2001 оноос 2006 он хүртэл 13.5 сая долларыг Монголын шүүхийн шинэтгэл төсөлдөө зарцуулжээ. Дэлхийн Банк 2001 оноос эхэлсэн шүүхийн шинэтгэлийн төсөлд 5 сая доллар зориулжээ. Тус банк 2008 оны 6 дугаар сард дахиад 5 сая долларыг “Чадавхийг дээшлүүлэх замаар Монголын шүүх эрх мэдлийг дэмжиж, тэдний суурхай ажиллагаа, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сайжруулах”-д зарцуулахаар болжээ. Үүний томоохон хэсгийг Дээд шүүхийн байрыг засан, тохижуулахад зориулах аж.

<sup>2</sup> Жишээ нь, Kenneth W. Dam, The Law-Growth Nexus: The Rule of Law And Economic Development [Эрх зүй, өсөлт хоёрын огтлолцол: Эрх зүйт ёс ба эдийн засгийн хөгжил] (2006); and, Ana Palacio (ed.), Law, Equity and Development, [Эрх зүй, шударга хуваарилалт, хөгжил] The World Bank Legal Review, Volume 2 (2006) зэрэг номыг үз.

<sup>3</sup> Дээрхийг үз.

<sup>4</sup> L. Sumati and Ts. Sergelen, Trend Lines in Public Perception of Judicial System Administration in Mongolia: Comparative Study Based on Nationwide surveys 2001, 2003, 2005, 2007 [Монгол дахь шүүхийн тогтолцооны талаарх олон нийтийн санаа бодлын чиг хандлага: 2001, 2003, 2005, 2007 оны бүх нийтийн санал асуулгын дүнд тулгуурласан харьцуулан судалгаа] (Sant Maral 2007).

<sup>5</sup> Дээрхийг үз.

<sup>6</sup> Дээрхийг үз.

<sup>7</sup> Дээрхийг үз.

Түүнээс гадна шүүхээр үйлчлүүлсэн болон үйлчлүүлж үзээгүй хүмүүсийг хооронд нь харьцуулахад эхний бүлгийн шүүхэд итгэх итгэл нь үлэмж доогуур байх бөгөөд эл байдал даамжирсаар 2005 оноос хойш тэдний шүүхэд хандах таагүй хандлага нь гурав дахин дорджээ.<sup>8</sup>

Арваад жил үргэлжилсэн шүүхийн шинэтгэлийн үр дүнд шүүхэд итгэх олон нийтийн итгэл мэдэгдэхүйц сайжирч чадаагүй байдалд дүгнэлт хийж Нээлттэй Нийгэм Форумаас (ННФ) “Шүүхийн шинэтгэл төсөл” санаачилж байна.

Төслийн эхний шатанд ННФ нь Монгол дахь шүүхийн шинэтгэлийн ахиц дэвшил чухам ямар түвшинд байгааг тогтоох, шүүхийн тогтолцоонд бодитой оршиж байгаа болон мэдрэгдэж байгаа дутагдлыг ялган зааглах, цаашид ахиц дэвшил гаргахын тулд ННФ-аас баримтлах стратегийг боловсруулахад тус дөхөм болох үүднээс эрэлт хэрэгцээний судалгаа хийв. Уг эрэлт хэрэгцээний судалгааны үр дүн болон Шүүхийн шинэтгэл хөтөлбөрийг ННФ-ын зүгээс хэрхэн чиглүүлэх талаар гаргасан зөвлөмжийг дор танилцуулав.

## АРГАЧЛАЛ

Шүүхийн шинэтгэлийн хүрсэн түвшинд үнэлэлт дүгнэлт өгөх нь тийм ч амархан хэрэг биш байдаг. Юуны өмнө, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэгдсэн аргачлал байхгүй төдийгүй шинэтгэл хэр амжилттай болсныг үнэлэхэд ямар шалгуур хамгийн чухал вэ гэдэг дээр нэгдсэн ойлголтод хүрээгүй байна. Мөн шүүхийн шинэтгэлийн зорилтуудаас шүүхийн бие даасан байдал, шударга байдал, голч хандлага, түүгээр ч үл барам үйл ажиллагааны шуурхай байдлыг хүртэл тодорхой хэмжээнд тоон үзүүлэлт гэхээс илүү чанарын үзүүлэлтээр үнэлэх хандлагатай байна.

Гэсэн хэдий ч бие даасан, шударга, голч, шуурхай байхын тулд шүүх ямар үзүүлэлтийг хангасан байх ёстой вэ гэдгийг тогтоох боломж бий. Жишээ нь, бие даасан шүүхийн шийдвэр нь төрийн эрх мэдлийн бусад салаа мөчир болон төрийн албан тушаалтны нөлөөнөөс ангид байна. Мөн төв голч байхын тулд шүүх нь хэргийн зохигчид болон бусад сонирхогч этгээдээс төлбөр мөнгө, бэлэг сэлт авах, тал тохой татах хэлбэрээр нөлөөнд автахгүй байна. Бие даасан, төв голч, мэргэжлийн шаардлага хангасан, шуурхай ажиллагаатай байх нь шүүхийг үнэлэх үзүүлэлт (мөн шинэтгэлийн зорилт) гэж үзвэл тухайн шүүхийн тогтолцоог үнэлэхэд хамгийн гол асуудал нь дээрх үзүүлэлт ямар түвшинд байгааг бодитойгоор тодорхойлж тоогоор харуулах явдал юм.

Ийм нэг аргыг “Шүүхийн шинэтгэлийн индекс” гэж нэрлэх бөгөөд Америкийн Барын Холбооны Эрх зүйт ёс санаачлагаас ардчилалыг шинээр тогтоосон болон шилжилтийн улсууд дахь шүүхийн шинэтгэл, шүүхийн бие даасан байдлын үнэлгээг хийх зорилгоор боловсруулан гаргасан байна. Энэхүү индексийг

---

<sup>8</sup> Дээрхийг үз.

<sup>9</sup> Жишээ нь Гүрж улсын Шүүхийн шинэтгэлийн индексийг үз. Америкийн Барын Холбоо 2005, Дараахь хаягт бий: <http://www.abanet.org/rol/publications/georgia-jri-2005-eng.pdf>

боловсруулахдаа Эрх зүйт ёс санаачлагаас “хариуцлагатай, үр өгөөжтэй, бие даасан” шүүх байгуулахад түлхэц үзүүлэх 30 хүчин зүйлийг гаргаж<sup>9</sup> тус бүрт нь тодорхойлолт өгсөн байна. “Үндэстэн ястан, шашны цөөнх болон хүйсийн төлөөлөл шүүхийн байгууллагад ажиллагсад болон хүний нөөцөд жигд хангагдсан байх” гэх зэргээр. Тэгээд хүчин зүйл бүрээр эерэг, сөрөг, саармаг гэсэн гурван үнэлгээний аль нэгийг сонгоно. Хэрэв аль нэг хүчин зүйлийн тодорхойлолт нь тухайн улсын бодит байдлыг илэрхийлж байвал тэр хүчин зүйлийн хувьд эерэг үнэлгээ авна. Харин тодорхойлолт нь тэр улс дахь нөхцөл байдлыг огт илэрхийлж чадахгүй бол сөрөг үнэлгээ авна. Хэрэв зарим талаар таараад, зарим талаар таарахгүй байгаа бол саармаг үнэлгээ авна. Түүнээс гадна хүчин зүйлүүдийг бүлэглэн хэд хэдэн категори болгосон байна. Тухайлбал, Чанар, Боловсрол, Олон янз байдал, Шүүхийн эрх мэдэл, Санхүүгийн нөөц бололцоо, Бүтцийн хамгаалалт, Хариуцлага, Ил Тод Байдал, Шуурхай байдал гэх мэт. Хүчин зүйлийг ингэж бүлэглэснээр дурын нэг салбар, чиглэлд тухайн улс ямар түвшинд байгаа талаар төсөөлөл авах боломж олгоно.<sup>10</sup>

Дээрх загвар олон сайн талтай. Тиймээс ч ННФ тэдгээрийг Монголын шүүхийн тогтолцоог үнэлэх аргачлалдаа багтаан оруулахыг эрмэлзсэн байна. Гэвч бас сул талууд ч байгаа. ННФ тэдгээрийг тойрч гарахыг мөн эрмэлзжээ.

Юуны өмнө Шүүхийн Шинэтгэлийн Индекс орсон хүчин зүйлүүд нь бүгд шүүхийн шинэтгэлийн хүрсэн түвшинг үнэлэхэд хамаатай боловч шүүхийн шинэтгэлийн бусад мэргэжилтнүүд өөр хэд хэдэн хүчин зүйлийг чухалчлан авч үзсэн байдаг.<sup>11</sup> Шүүхийн Шинэтгэлийн Индекс нь шүүгчдийн үнэнч, шударга байдал, хариуцлага, ил тод байдлыг бүрэн дүүрэн буюу шууд авч үзээгүй. Гэтэл эдгээр нь ННФ-ын хувьд маш чухал хүчин зүйлүүд. Иймд ННФ хүчин зүйлийн тоог 60 болгон өргөжүүлж, Монголын шүүхийн тогтолцоог үнэлэхэд ашигласан байна.<sup>12</sup>

Шүүхийн Шинэтгэлийн Индексийн бас нэг сул тал нь тухайн хүчин зүйл бүрээр өгсөн үнэлгээ нь “шүүхийн тогтолцооны талаар нарийн мэдэх шүүгчид, өмгөөлөгчид, сэтгүүлчид, гадны ажиглагчдыг хамарсан түүвэр бүлгээс цөөхөн хэдэн асуулт тавьж хариу авсны дараа” “тухайн улс, бүс нутгийн талаар ерөнхийд нь мэдэх” гэх нь арай хязгаарлагдмал юм. Судалгаанд хамрагдсан мэргэжилтний өрөөсгөл үзэл хандлагаас болж дүгнэлт нь эргэлзээнд орох эрсдэлтэй. Учир нь мэргэжилтэн, ялангуяа тухайн орны талаар ерөнхий мэдлэгтэй болохоор мэдсээр

---

<sup>10</sup> Гэхдээ Шүүхийн шинэтгэлийн индекс нь шүүхийн тогтолцооны шинэтгэлд гарсан ахиц дэвшлийн талаар уншигч өөрөө дүгнэлт хийж, өөрийн гэсэн ойлголттой болохыг шаарддаг.

<sup>11</sup> Жишээ нь Lin Hammergen, Diagnosing Judicial Performance: Toward a Tool to Help Guide Judicial Reform Programs [Шүүхийн үйл ажиллагааг оншлох нь: Шүүхийн шинэтгэлийн хөтөлбөрийг чиглүүлэхэд туслах аргачлал боловсруулах асуудалд] (Transparency International).

<sup>12</sup> Хүчин зүйлүүд тооны хувьд зөрөөтэй болсны нэг шалтгаан бол ННФ Шүүхийн Шинэтгэлийн Индекс орсон зарим хүчин зүйлийг дотор нь задалж авч үзсэн явдал юм. Жишээ нь, “Шүүхэд ажилд орохоор өргөдөл өгсөн болон ажиллаж байгаа хүмүүсийн дотор үндэстэн ястны цөөнх болон хүйсийн төлөөлөл орсон байдаг” гэсэн ганц өгүүлбэрээр асуухын оронд Нээлттэй Нийгэм асуулгын хуудсан дээр үүнийг тусдаа асуулт болгон задалж, цөөнхийн тухай нэг асуулт, хүйсийн төлөөллийн тухай бас нэг асуулт болгосон. Түүнчлэн, Шүүхийн шинэтгэлийн индекс “Шүүхийн шийдвэр нь гагцхүү хэргийн баримт, хуульд үндэслэж, ахлах шүүгч, хувийн сонирхол, төрийн бусад байгууллагын зүгээс аливаа зүй бус нөлөөллөөс ангид байдаг,” гэж асуусан байхад Нээлттэй Нийгэм асуулгын хуудас үүнийг хэд хэдэн асуулт болгон задалж шүүхийн шийдвэрт зүй бусаар нөлөөлөх бусад зүйлийн талаар асуулт нэмж оруулсан.

атлаа эсвэл санамсаргүйгээр өөрийн өмнө нь бий болсон ойлголтоор хандаж, тэр орны шүүхийн тогтолцоог үнэлэх нь гарцаагүй. Нийгмийн ухааны эрдэмтэд нийтлэг хүлээн зөвшөөрсөн үзлээр бол мэргэжилтэн өөрийнх нь сэтгэгдэл, үзэл бодлыг зөв мэт харагдуулж байгаа мэдээллийг түүж аваад, харин тийм биш мэдээллийн үнэ цэнийг бууруулах буюу өөрөөр тайлбарладаг тал бас бий.

Ийнхүү өрөөсгөл хандлага гарах эрсдлийг арилгахын тулд ННФ-ын үнэлгээ нь 30 орчим мэргэжилтний Монголын шүүхийн талаарх хамтын дүгнэлтэд үндэслэсэн ба тэдгээр нь Хавсралт А-д байгаа нэргүй санал асуулгыг бөглөж, 60 хүчин зүйл тус бүрээр шүүхийг үнэлсэн болно.

Шүүхийн шинэтгэлийн индексийн талаарх бас нэг болгоомжлол бол хүчин зүйл бүрээр зөвхөн эерэг, сөрөг, хэлж мэдэхгүй гэсэн хариулт авч байгаа явдал юм. Үнэлгээний ийм хариулт нь хялбар боловч хүчин зүйл бүр дээр дээшээ, доошоо гэснээс илүү мэдээлэл өгч чадахгүй бөгөөд бүрэн эерэг, сөрөг, эсвэл ялимгүй эерэг, сөрөг үнэлгээг хооронд ялгахгүй байгаа юм. Түүнээс гадна, эерэг буюу сөрөг үнэлгээ нь, дээр хэлсэнчлэн, ганц нэг буюу цөөн хэдэн хувь хүний субъектив дүгнэлтийг илэрхийлэх тул бодитойгоор дамжуулж байгаа мэдээллээс нь илүү их мэдээлэл гарч ирж байгаа мэт харагдана.

Үүний эсрэгээр, ННФ хүчин зүйл бүр дээр гуч гаруй мэргэжилтний хамтын дүгнэлтэд тулгуурлан тоон үнэлгээ өгсөн.<sup>13</sup> Уг үнэлгээ нь 1-ээс 5 хүртэл шатлалаар мэргэжилтэн бүрээс тухайн батлах өгүүлбэр Монголын шүүхийн байдлыг хэр зэрэг тусгаж байгааг асуусан асуултын дундаж хариуг илэрхийлнэ (“1” нь “Огт санал нийлэхгүй байна” харин “5” нь “Бүрэн санал нийлж байна” гэсэн утгатай). 3-аас доош оноо авбал тэнцэхгүй (3 нь “Хэлж мэдэхгүй” гэсэн утгатай) харин 3-аас дээш оноо авбал тэнцэнэ. “Монголын шүүхийн танилцуулах хуудсан дээр ийм байдлаар оруулсан. Танилцуулах хуудас нь мөн тухайн өгүүлбэртэй санал нийлж байгаа эсвэл нийлэхгүй байгаа мэргэжилтний эзлэх хувийн жинг харуулах ба энэ нь Монголын шүүхийн талаар нийтлэг санал нэгдэж байгаа чиглэлийг тогтоох зорилготой. Эцэст нь, танилцуулах хуудас нь Шүүхийн шинэтгэлийн индексийн нэгэн адил хүчин зүйлүүдийг категори болгон хувааж (жишээ нь: “Үзэл бодолдоо үнэнч”), харин түүнээс ялгарах онцлог нь, категори бүрт ерөнхий үнэлгээг *онц сайн, хангалттай, ялимгүй хангалттай, ялимгүй хангалтгүй, хангалтгүй, огт хангалтгүй* гэсэн үгээр илэрхийлсэн.

Эдгээр ерөнхий үнэлгээг дан ганц тооноос гадна агуулгыг нь нэмэн баяжуулах үүднээс ННФ мөн бичгээр тайлбар гаргахыг судалгаанд оролцсон хүмүүсээс

---

<sup>13</sup> ННФ мөн судалгааны асуулгыг Дээд шүүхийн судалгааны төвд хүргүүлж, Дээд шүүх өөрийгөө хэрхэн дүгнэж байгааг гадны мэргэжилтнүүдийн үнэлгээтэй харьцуулж үзэхийг зорисон. Ийм найман асуулгыг тарааж, хурааж аваад, ННФ-д хариу ирүүлсэн. Асуулгын хоёроос бусад нь асуулгын маягт дээр хүсэлт болгосны дагуу түүнийг бөглөсөн хүний ажил, албан тушаалын талаар асуулт ороогүй. Тиймээс тэдгээр асуулгыг Дээд шүүхийн шүүгчийн туслах зэрэг ажилтан, судалгааны төвийн ажилтан, эсвэл Дээд шүүхийн шүүгчийн аль нь бөглөсөн гэдгийг мэдэх боломжгүй байсан. Түүнээс гадна анкетыг Дээд шүүх дээр нэг этгээд цуглуулж авсан учраас судалгаанд оролцогчдын нэрийг нууцлах, анкетыг бөглөхдөө дараа нь арга хэмжээ авахаас айх зүйлгүйгээр асуултад хариулах боломж алдагдсан. Тиймээс эдгээр асуулгыг тоон үнэлгээ өгөхөд оруулж тооцоогүй болно. Ерөнхийд нь харахад Дээд шүүхээс авсан асуулга гадны мэргэжилтэнтэй харьцуулахад илүү өндөр үнэлгээ өгсөн байв. Ялангуяа шүүх өөрийн үзэл бодолдоо үнэнч байх үзүүлэлтийн хувьд энэ нь маш тод илэрч байв. Дээд шүүх энэ үзүүлэлтийг өндөр үнэлсэн байхад мэргэжилтнүүд маш доогуур үнэлсэн байв. Нөгөө талаар, Дээд шүүхийн судалгаа ажиллах нөхцөл бололцоог сайжруулах хэрэгцээ шаардлага байна гэж үзсэн байхад гадны мэргэжилтнүүд шүүхийн ажиллах бололцоо хангалттай түвшинд байгаа гэж дүгнэсэн байв.



хүссэн ба олон хүн энэ боломжийг ашигласан. Мөн ННФ Дээд шүүхийн шүүгч, нэртэй өмгөөлөгч, хуулийн багш профессор, төрийн бус байгууллагын удирдлага, төрийн албан хаагч, хууль сахиулах байгууллагын ажилтан зэрэг янз бүрийн мэргэжилтнээс Монголын шүүхийн талаар ярилцлага авсан. Хэдийгээр ярилцлага өгсөн болон асуулгад оролцсон хүмүүсийн дүгнэлтүүд хоорондоо шууд таарахгүй байсан ч гэсэн тэдгээр ярилцлагын үед цуглуулсан тайлбарыг ашиглан тоон үзүүлэлтийн учрыг тайлж, дор авч үзсэн болно.

Эцэст нь хэлэхэд, ННФ Монголын шүүхийн шинэтгэлд оролцож байгаа олон улсын төрөл бүрийн байгууллагуудтай зөвлөлдсөн нь тэдний баялаг туршлагаас суралцах төдийгүй бас Монголын шүүхийн тогтолцоог сайжруулахын төлөө тэдний хийж байгаа ажилтай давхардал, зөрчилдөөн үүсгэхээс сэргийлсэн зорилготой байв. Жишээ нь, эдгээр уулзалтаас хийсэн нэг дүгнэлт бол шүүхийн шуурхай ажиллагаа, сургалтын талаарх асуултыг цөөлж, уг асуудлыг тойрч гарах нь зүйтэй байсан бөгөөд учир нь АНУ-ын ОУХА-ийн Шүүхийн шинэтгэл төсөл, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран явуулж байгаа үйл ажиллагаа үүнд голчлон чиглэж байгаа билээ.

## ҮНЭЛГЭЭНИЙ БАГ

Аризонагийн их сургуулийн Жэймс Е. Рожерсийн нэрэмжит Хуулийн коллежийн дэд профессор Брент Т. Уайт, ННФ-ын ажилтан П.Бадамрагчаа нар болно.

# Монгол дахь шүүхийн шинэтгэлийн байдлыг ДҮГНЭХ ХҮСНЭГТ

Дараахь Дүгнэх Хүснэгт нь Монгол дахь Шүүхийн Шинэтгэлийн Байдлын талаарх ерөнхий төсөөлөл өгөх зорилготой юм. Түүнийг дэлгэрэнгүй тайлбарласан хэсэгтэй холбож үзнэ үү.

## ЧАНАР, СУРГАЛТ, ОЛОН ЯНЗ БАЙДАЛ – ХАНГАЛТГҮЙ

Шүүгчид мэргэжлийн хувьд сайн бэлтгэгдсэн. (Шүүгчид нь албан ёсны хууль зүйн дээд боловсрол эзэмшиж, шүүгчийн албан тушаалд ажиллахаас өмнө практик дадлага хийсэн.)	2.4*	Санал нийлэхгүй байна 66%** Санал нийлж байна 20% Хэлж мэдэхгүй 14%	Тэнцээгүй
Шүүгчид сургалтад сайн хамрагдсан. (Шүүгчийн албан тушаалд ажиллахаас өмнө материаллаг болон процессийн эрх зүйн гол гол салбарын сэдвээр болон шүүгчийн нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар холбогдох сургалтад суусан байх ёстой.)	2.4	Санал нийлэхгүй байна 57% Санал нийлж байна 19% Хэлж мэдэхгүй 24%	Тэнцээгүй
Шүүгчид хууль зүйн үргэлжилсэн сургалтад шаардлага хангахуйц түвшинд хамрагддаг. (Хуульд орсон өөрчлөлт, хөдөлгөөний талаар хангалттай мэдээлэл өгч чадахуйц мэргэжлийн түвшинд боловсруулсан хөтөлбөрөөр шүүгчид тогтмол сургалтад хамрагддаг байх ёстой.)	3.3	Санал нийлэхгүй байна 19% Санал нийлж байна 43% Хэлж мэдэхгүй 33%	Тэнцсэн
Цөөнхийн төлөөлөл. Үндэстний болон шашны цөөнхөөс шүүгчээр ажиллаж байгаа хүмүүсийн тоо нь эдгээр цөөнхийн нийт хүн амд эзлэх хувьтай хангалттай хэмжээнд дүйцэж байх.	2.5	Санал нийлэхгүй байна 42% Санал нийлж байна 21% Хэлж мэдэхгүй 37%	Тэнцээгүй
Хүйсийн тэнцвэртэй харьцаа. Эрэгтэй, эмэгтэй шүүгчдийн тоо шүүхийн тогтолцооны бүх шатанд бараг ижил байдаг.	2.0	Санал нийлэхгүй байна 77% Санал нийлж байна 5% Хэлж мэдэхгүй 18%	Тэнцээгүй

\* Уг үнэлгээ нь 1-ээс 5 хүртэл шатлалаар мэргэжилтэн бүрээс тухайн батлах өгүүлбэр Монголын шүүхийн байдлыг хэр зэрэг тусгаж байгааг асуусан асуултын дундаж хариуг илэрхийлнэ ("1" нь "Огт санал нийлэхгүй байна" харин "5" нь "Бүрэн санал нийлж байна" гэсэн утгатай). 3-аас доош оноо авбал тэнцэхгүй (3 нь "Хэлж мэдэхгүй" гэсэн утгатай) харин 3-аас дээш оноо авбал тэнцэнэ.

\*\* Тухайн өгүүлбэртэй санал нийлж байгаа болон санал нийлэхгүй байгаа мэргэжилтний эзлэх хувийн жинг гаргасан, "Бүрэн санал нийлж байна," "Санал нийлж байна" хоёрыг нэгтгээд, мөн "Санал огт нийлэхгүй байна," "Санал нийлэхгүй байна" хоёрыг нэгтгэсэн. Үүний задаргааг Хавсралт В-ээс үзнэ үү.

Чанар, сургалт, олон янз байдал нь Монголын шүүх үлэмж амжилт гаргасан чиглэл юм. Гэвч энд өгсөн үнэлгээнээс харахад хийх зүйл их байна. Нэг чухал онцлох зүйл бол шүүгчдэд зориулсан хууль зүйн үргэлжилсэн сургалт юм. Энэ нь ГТХАН, АНУ-ын ОУХА-ын Шүүхийн шинэтгэлийн төсөл, Дэлхийн Банкны голлон анхаарч ирсэн чиглэл бөгөөд тэд шүүгчид болон бусад хуульчдыг сургахад зориулж Хууль зүйн үндэсний төвийг байгуулахад тусламж үзүүлсэн юм.<sup>14</sup> Мэргэжилтний нэлээд хэсэг нь буюу 43 хувь нь шүүгчид үргэлжилсэн сургалтад бүрэн хамрагддаг гэдэгтэй санал нийлж байхад дөнгөж 19 хувь нь санал нийлэхгүй гэснээс үзэхэд эдгээр байгууллагын хүчин чармайлт амжилт олсны илрэл юм.

Нөгөө талаар, 66 хувь нь шүүгчид суурь мэргэжлийн хувьд сайн бэлтгэгдсэн байдаг гэдэгтэй санал нийлээгүй ба 57 хувь нь шүүгчид ажилд томилогдохоос өмнө хангалттай сургалтад хамрагддаггүй гэж үзсэн байна. Мэргэжилтнээс авсан ярилцлага, тайлбарт үндэслэн ийм доогуур үзүүлэлт авсан шалтгааныг гаргаж ирэх боломжтой. Зарим мэргэжилтэн шүүгч болох хамгийн зөв зам бол эхлээд шүүхийн нарийн бичгийн даргаар ажиллах гэсэн байна. Мөн олон мэргэжилтэн

ШҮҮХИЙН ЭРХ МЭДЭЛ / ХҮЧ НӨЛӨӨ – ХАНГАЛТГҮЙ			
Хууль тогтоомж болон албан тушаалтны акт, шийдвэр нь Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг тогтоож эцсийн шийдвэр гаргах эрхийг шүүх эдэлнэ.	4	Үндсэн хуульд заасан	Тэнцсэн
Иргэний эрх, эрх чөлөөтэй холбоотой бүх хэрэг зөвхөн шүүх харьяалалд багтаж, шүүх эцсийн шийдвэр гаргана.	4	Үндсэн хуульд заасан	Тэнцсэн
Төрийн эрх мэдлийн бусад салаа мөчир нь шүүхийн шийдвэрийг хүндэтгэж, албадан биелүүлдэг.	2.7	Санал нийлэхгүй байна 50% Санал нийлж байна 32% Хэлж мэдэхгүй 18%	Тэнцээгүй
Шүүхийн шийдвэрийг гагцхүү давж заалдах болон хяналтын шатанд хүчингүй болгож болдог.	3.8	Санал нийлэхгүй байна 9% Санал нийлж байна 82% Хэлж мэдэхгүй 9%	Тэнцсэн
Шүүх нь иргэнийг шүүхэд дуудан ирүүлэх, шүүхийг үл хүндэтгэсэн тохиолдолд арга хэмжээ авах, албадлага хэрэглэх эрх хэмжээ бүрэн хангагдсан.	3.9	Санал нийлэхгүй байна 9% Санал нийлж байна 82% Хэлж мэдэхгүй 9%	Тэнцсэн
Шүүх нь иргэнийг шүүхэд дуудан ирүүлэх, шүүхийг үл хүндэтгэсэн тохиолдолд арга хэмжээ авах, албадлага хэрэглэх эрх хэмжээ нь төрийн бусад байгууллагын дэмжлэгийг хүлээж, хэрэгждэг.	3.8	Санал нийлэхгүй байна 5% Санал нийлж байна 77% Хэлж мэдэхгүй 18%	Тэнцсэн
Төрийн бусад байгууллага нь шүүхийн шийдвэрийг үгүйсгэсэн шийдвэр гаргах, үл тоох явдал гаргадаггүй бөгөөд хэрэв тэгвэл шүүхэд гомдол гаргаж болдог.	3	Санал нийлэхгүй байна 36% Санал нийлж байна 41% Хэлж мэдэхгүй 22%	Хэлж мэдэхгүй

<sup>14</sup> Хууль зүйн үндэсний төвийн барилгын санхүүжилтыг Дэлхийн Банк хийсэн.

шүүгчийг сонгон ажиллуулахад садан төрлийн холбоо харилцаа хамгийн гол үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ихэнх шүүгчийн албан тушаалыг хэд хэдэн садан төрлөөр нэгдсэн сүлжээ эзэлж байгаа хэмээн шүүмжилсэн байна. Түүнээс гадна шүүгчийг сонгох үйл явц нь маш их улс төрждөг ба Ерөнхийлөгч үүнд харьцуулашгүй хүчтэй нөлөө үзүүлдэг учраас Ерөнхийлөгчид хэн үнэнч байна вэ гэдэг нь бусад бүх асуудлаас илүү чухал болдог. Ингээд, Дээд шүүх болон доод шатны шүүхийн шүүгчдийг ялгаатай авч үзсэн хүн олон байсан ба Дээд шүүхийн шүүгчид мэргэжлийн хувьд өндөр түвшинд байхад доод шатны шүүгчдийн дотор олон шүүгч тийм биш байдаг гэжээ.

Монголын шүүхэд хуулиар эрх мэдэл, хүч нөлөө үзүүлэх боломж нь олгогдсон байна. Тийм учраас энэ үзүүлэлтээр илүү өндөр үнэлгээ авсан. Монголын шүүхэд байвал зохих ихэнх эрх мэдлийг Үндсэн хуулиар баталгаажуулсан байна. Жишээ нь, 47-р зүйлийн 1 дэх заалтад “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ,” 50.2-т “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ.” 50.1.3-т Дээд шүүх нь “хууль түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар .. асуудлыг хянан шийдвэрлэнэ.” гэж тус тус заасан.

Түүнээс гадна Монгол Улс бие даасан, дагнасан<sup>15</sup> Үндсэн хуулийн шүүхтэй бөгөөд түүнийг Үндсэн хуулийн цэц гэнэ. Цэц нь Үндсэн хуулийг тайлбарлах дээд эрх мэдэлтэй,<sup>16</sup> мөн “хууль, зарлиг Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ” нь Үндсэн хуульд нийцээгүй бол түүнийг хүчингүй болгох эрхтэй.<sup>17</sup>

Гэсэн хэдий ч, санал асуулгад оролцсон мэргэжилтний 50 хувь нь “Шүүхийн шийдвэрийг төрийн эрх мэдлийн бусад салаа мөчир нь хүндэтгэж, албадан биелүүлдэг” гэсэн бодомжтой санал нийлээгүй. Мөн үүний адилаар ярилцлага өгсөн хэд хэдэн мэргэжилтэн хэлэхдээ гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нь өөртөө таалагдаагүй шүүхийн шийдвэрийг хүндэтгэж үздэггүй гэв. Жишээ нь, нэгэн өмгөөлөгч татварын алба Дээд шүүхийн шийдвэрийг үл тоомсорлож байсан тохиолдлыг яриад, түүний шалтгааныг тэрээр өөрөө Дээд шүүх хуулийг буруу тайлбарласан хэмээн итгүүлж чадсан явдал байсан гэв. Үүнээс үзэхэд бодит байдал дээр Дээд шүүх хууль тайлбарлах дээд эрх мэдлийг хэрэгжүүлдэггүй бөгөөд гүйцэтгэх эрх мэдлийн, тэр бүү хэл татварын байцаагч нар, санал нийлэхгүй л бол Дээд шүүхийн шийдвэрийг үл хэрэгсэж болдог юм байна гэсэн болгоомжлол төрүүлж байна. Үндсэн хууль нь ч гэсэн Дээд шүүхэд олгосон гэх “дээд эрх мэдэл” гэдэг ойлголтыг өөрөө үгүйсгэсэн байна. 50-р зүйлийн 2-т Улсын Дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ гэж тов тодорхой заажээ. Тэгэхээр Дээд шүүхийн тайлбар хуульд харшилж буй эсэхийг тогтоох эрхтэй этгээд нь хэн байх вэ гэдгийг Үндсэн хуульд бүрхэг болгож орхисон байна.<sup>18</sup>

---

<sup>15</sup> 62. 2 дах заалтыг үз. Үндсэн хуулийн Цэц, түүний гишүүд нь үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуулийг удирдлага болгох ба бусад аливаа байгууллага, албан тушаалтан, өөр хэнээс хараат бус байна.

<sup>16</sup> 62 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

<sup>17</sup> 64 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг.

<sup>18</sup> Хэдийгээр Үндсэн хуульд зааснаар Дээд шүүх тэрхүү шийдвэрийг гаргах ёстой боловч Монголд амьдрал дээр тийм биш байдаг гэсэн хариулт өгсөн байна. 50 дугаар зүйлийн 2 дах хэсгийг үз. “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ.”

## НӨХЦӨЛ БОЛОЛЦОО, ДЭД БҮТЭЦ – ЯЛИМГҮЙ ХАНГАЛТТАЙ

Шүүхийн нийт төсөв нь шүүхээр үйлчлүүлэх эрэлт хэрэгцээг хангахуйц түвшинд байдаг.	2.8	Санал нийлэхгүй байна 33% Санал нийлж байна 29% Хэлж мэдэхгүй 38%	Тэнцээгүй
Шүүхийн нийт төсөв улсын төсөв нэмэгдэх хэрээр өсч байдаг.	3	Санал нийлэхгүй байна 19% Санал нийлж байна 23% Хэлж мэдэхгүй 58%	Хэлж мэдэхгүй
Төрийн эрх мэдлийн бусад салаа мөчиртэй эн зэрэгцэх байр суурийг нь харгалзан үзэж улсын төсвөөс шүүхэд олгох хувийг тогтоодог.	3.2	Санал нийлэхгүй байна 19% Санал нийлж байна 47% Хэлж мэдэхгүй 33%	Тэнцсэн
Шүүгч, шүүхийн захиргааны албан хаагчдад ашиглуулж байгаа албан өрөө, тасалгаа нь үүргээ гүйцэтгэх нөхцлийг хангасан байдаг.	3.2	Санал нийлэхгүй байна 41% Санал нийлж байна 50% Хэлж мэдэхгүй 9%	Тэнцсэн
Шүүхийн тогтолцоо нь хэргийн ачааллаа даахуйц хэмжээнд шуурхай ажиллахад шаардлагатай тооны компьютер, бусад тоног төхөөрөмж ашиглан үйл ажиллагаагаа явуулдаг.	3.9	Санал нийлэхгүй байна 5% Санал нийлж байна 78% Хэлж мэдэхгүй 18%	Тэнцсэн
Шүүгч бүрт ажлаа хийхэд нь, тухайлбал, бичиг баримт боловсруулах, хууль зүйн судалгаа хийхэд шаардлагатай туслах ажилтан байдаг.	3.7	Санал нийлэхгүй байна 10% Санал нийлж байна 80% Хэлж мэдэхгүй 10%	Тэнцсэн
Хэрэгцээ шаардлага бий болмогц шүүхийн орон тоог шинээр нэмэгдүүлж байдаг тогтолцоо бий болсон.	2.8	Санал нийлэхгүй байна 28% Санал нийлж байна 19% Хэлж мэдэхгүй 52%	Тэнцээгүй
Шүүгчдийн цалин хангамж хүрэлцээтэй байдаг. (Шүүгчдийн цалин хангамж нь хувийн секторт сайнд тооцогдох цалинтай дүйцэхүйц, мэргэжлийн өндөр ур чадвартай шүүгчдийг татаж, тогтвортой ажиллуулах хэмжээний байх бөгөөд орлогын өөр эх үүсвэр хайхгүйгээр ар гэрээ тэжээн тэтгэж, боломжийн аюулгүй орчинд амьдрах боломжоор хангахуйц байдаг.)	2.0	Санал нийлэхгүй байна 36% Санал нийлж байна 46% Хэлж мэдэхгүй 18%	Хэлж мэдэхгүй
Шүүхийн байр нь шударга ёсыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтэц бүхий бөгөөд хүндэтгэл төрүүлэхүйц орчин бүрдсэн байдаг.	2.1	Санал нийлэхгүй байна 63% Санал нийлж байна 5% Хэлж мэдэхгүй 32%	Тэнцээгүй

Нөхцөл бололцоо, дэд бүтэц бол Монголын шүүх үлэмж ахиц дэвшил гаргаж чадсан бас нэг салбар юм. Олон улсын хандивлагчдын өгөөмөр тусламж дэмжлэг энэ амжилтад шийдвэрлэх үүрэгтэй байжээ. Жишээ нь АНУ-ын ОУХА нийслэлийн болон бусад 8 шүүхийг орчин үеийн тоног төхөөрөмж (компьютер, тавилга, дуу авиа)-өөр тоноглож, Дэлхийн Банкны Шүүхийн шинэтгэлийн төсөл Дээд шүүх болон нийслэл, Дархан-Уул аймгийн захиргааны шүүхийн байрыг засварлах, шүүх хурлын танхимын тавилгыг шинэчлэх ажлыг санхүүжүүлсэн байна. Иймээс

ч санал асуулгад оролцогчдын 78-аас дээш хувь нь “Шүүхийн тогтолцоо нь хэргийн ачааллаа даахуйц хэмжээнд шуурхай ажиллахад шаардлагатай тооны компьютер, бусад тоног төхөөрөмж ашиглан үйл ажиллагаагаа явуулдаг” гэдэгтэй санал нийлсэн байна.

Түүнчлэн Монгол Улс шүүхийг туслах ажилтнаар хангах чиглэлд ихээхэн амжилтад хүрсэн байна. Саяхан шүүгч бүр туслахтай болжээ. Иймээс ч санал асуулгад оролцогчдын 80 хувь нь “Шүүгч бүрт ажлаа хийхэд нь, тухайлбал, бичиг баримт боловсруулах, хууль зүйн судалгаа хийхэд шаардлагатай туслах ажилтан байдаг” гэдэгтэй санал нийлсэн байна.

Шүүгчдийн цалин хангамж ч бас сүүлийн үед нэмэгдэж, доод шатны шүүхийн шүүгч сард 300-400 доллар, Дээд шүүхийн шүүгч сард 700 доллар орчим цалин хөлс авч байна. Ийм хэмжээний цалинтай байхад шүүгч ерөнхийдөө ар гэрээ тэжээн тэтгэж, боломжийн аюулгүй орчинд амьдрахад хүрэлцээтэй хэдий ч тэдний хэрэгцээг дөнгөж хангах төдий л байгаа юм. Гэсэн хэдий ч хувийн секторт ажиллаж байгаа зарим хуульчийн цалинтай харьцуулахад том ялгаа гарна. Улаанбаатарт компаний том хуульчид цагт 200 доллар авч байгааг харьцуулж үзвэл шүүгчийн цалингийн хэмжээ нь хамгийн шилдэг хуульчдыг яагаад ч татаж чадахааргүй байна. Нөгөө талаас, хэдий цалин бага ч гэсэн шүүгчийн ажил нэр хүндтэй ажил гэдгээрээ ч хүний сонирхлыг татаж чадахгүй байна (харин албан тушаалаа урвуулан ашиглаж мөнгө олох арга хэрэгсэл гэдгээрээ хүний сонирхлыг татаж байж мэдэх юм).

Цаашилбал, сүүлийн хэдэн жилд шүүхийн байр танхимыг засаж сайжруулсан ч гэсэн санал асуулгад оролцогчдын дийлэнхи олонхи нь буюу 63 хувь нь шүүхийн байрууд нь бүхэлдээ шударга ёсыг сахиулах дэд бүтэц бүхий хүндэтгэл төрүүлэхүйц орчныг бүрдүүлж чадахгүй байсаар байна гэж дүгнэжээ.

Эцэст нь, шүүхийн төсөв бодит дүнгээрээ төдийгүй төрийн бусад байгууллагатай харьцуулахад бага байгаа бөгөөд улсын төсвийн 0.5 хувьд ч хүрэхгүй байна (энэ хувь нь бас жилээс жилд өсөж, буурдаг). Иймээс санал асуулгад оролцогчдын дөнгөж 29 хувь нь “Шүүхийн нийт төсөв нь шүүхээр үйлчлүүлэх эрэлт хэрэгцээг хангахуйц түвшинд байдаг” гэдэгтэй санал нийлжээ. Шүүхийн төсвийг улсын төсвийн тодорхой хувь, тухайлбал, 3, 2, бүр 1 хувь дээр ч юмуу эсвэл тогтмол барих тухай санал хэд хэдэн удаа гарсан ч хууль тогтоох байгууллага нь хүлээж аваагүй гэнэ. Үүнээс үүдэн шүүхийн төсөв нь өчүүхэн бага (шүүх өөрөө жилийн хугацаанд төлбөр хураамжаас олдог орлогоос нь ч бага) төдийгүй бусад төрийн эрх мэдлийн байгууллагын зүгээс өөртөө ашигтайгаар өөрчлөх боломжтой байгаа юм.

Ийнхүү, нөхцөл бололцоо, дэд бүтэц нь үлэмж сайжирсан хэдий ч энэ чиглэлээр цаашид хийх ажил хийсэн ажлаас хавьгүй их байна. Одоогийн төвшин нь өөдрөгөөр хандахад дөнгөж шаардлага хангах төдий л байна. Нөгөө талаас, энэ чиглэлд олон улсын хандивлагчид цаашид голлон анхаарвал ахих боломж гарч болох юм гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Дээр өгүүлсэнчлэн Монголын шүүгч хуулиар олгогдсон эрх мэдэлтэй, Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийн бусад салаа мөчрөөс хараат бус, бүх насаараа томилогддог боловч бодит амьдрал дээр шүүхийн бие даасан, хараат бус байдлын талаар цаашид бодууштай зүйл олон байна. Иймээс ч, санал асуулгад оролцсон

## БИЕ ДААСАН, ХАРААТ БУС БАЙДАЛ – ХАНГАЛТГҮЙ

<p>Шүүхийн тогтолцоо нь өөрийн төсвийг зохиоход хангалттай сайн оролцож, төсвөө өөрийн мэдэлд байлгадаг.</p> <p>(Хууль тогтоох болон/эсвэл гүйцэтгэх байгууллагын шийдвэрээр шүүхэд хуваарилж байгаа төсвийн хэмжээг тогтооход шүүх өөрөө оролцож, нөлөөлөх боломж бололцоо байдаг бөгөөд тэр нь бодитой хэрэгжихүйц байдаг. Төсвийн эс үүсвэр хуваарилагдсаны дараа шүүх төсөв, мөнгөний зарцуулалтад өөрөө хяналт тавьдаг.)</p>	3.1	<p>Санал нийлэхгүй байна 32% Санал нийлж байна 41% Хэлж мэдэхгүй 27%</p>	Тэнцсэн
<p>Шүүгчийг сонгож, томилох үйл ажиллагаа нь хараат бус, голч хандлага бүхий шүүгчийг гаргаж ирэх нөхцлийг бүрдүүлдэг.</p> <p>(Шүүгчийг шалгалтад тэнцсэн эсэх, хуулийн сургуульд суралцсан байдал, бусад сургалтад хамрагдсан байдал, мэргэжлийн ур чадвар, хуульчдын дунд хэр нэр хүндтэй эсэх гэсэн бодит шалгуурыг үндэслэн томилдог. Улс төрийн нөлөө орж ирэх боловч тогтолцоо нь бүхэлдээ хараат бус, голч хандлага бүхий шүүгчийг гаргаж ирэх нөхцлийг бүрдүүлдэг.)</p>	2.7	<p>Санал нийлэхгүй байна 54% Санал нийлж байна 32% Хэлж мэдэхгүй 14%</p>	Тэнцээгүй
<p>Шүүгчийн аюулгүй байдлыг хангалттай түвшинд хамгаалдаг.</p> <p>(Шүүгчийг дарамт шахалтад орох, халдлагад өртөх, амь насыг нь хороох зэрэг аюул заналаас хамгаалах нөхцөл бололцоо хангалттай бүрдсэн.)</p>	2.5	<p>Санал нийлэхгүй байна 55% Санал нийлж байна 14% Хэлж мэдэхгүй 32%</p>	Тэнцээгүй
<p>Шүүгчээр ажиллах эрх нь баталгаатай байдаг.</p> <p>(Шүүгч нь тогтоосон хугацаагаар томилогдох ба шүүгчээр ажиллах эрх нь баталгаатай байдаг буюу тэтгэврийн нас хүртэл юмуу нэлээд удаан хугацаа өнгөртөл хамгаалагдсан байдаг)</p>	3.9	<p>Санал нийлэхгүй байна 9% Санал нийлж байна 77% Хэлж мэдэхгүй 14%</p>	Тэнцсэн
<p>Шүүгч нь авьяас чадвар, үзэл бодолдоо үнэнч чанар, ажлын туршлага зэрэг бодит шалгуурт үндэслэн шүүхийн тогтолцооны доод шатнаас дээд шат уруу албан тушаал дэвшдэг.</p>	3.1	<p>Санал нийлэхгүй байна 23% Санал нийлж байна 36% Хэлж мэдэхгүй 41%</p>	Тэнцсэн
<p>Шүүгчийг гагцхүү албан үүргээ зөрчсөн тодорхой үйлдэл гаргасан тохиолдолд ажлаас нь өөрчлөх буюу өөр ямар нэг хэлбэрээр шийтгэж болох ба ингэхдээ бодит шалгуурт үндэслэсэн ил тод журам баримталдаг.</p>	3	<p>Санал нийлэхгүй байна 32% Санал нийлж байна 41% Хэлж мэдэхгүй 27%</p>	Хэлж мэдэхгүй
<p>Тодорхой нэг хэргийг шийдвэрлэхээр томилогдсон шүүгчийг гагцхүү ашиг сонирхлын зөрчил эсвэл ажлын хэт ачаалал зэрэг зохих үндэслэлээр өөрчилж болдог.</p>	3.1	<p>Санал нийлэхгүй байна 32% Санал нийлж байна 50% Хэлж мэдэхгүй 23%</p>	Тэнцсэн

## БИЕ ДААСАН, ХАРААТ БУС БАЙДАЛ – ХАНГАЛТГҮЙ

Шүүгчдийн эвсэл, холбоо байгуулагдсан бөгөөд түүний цорын ганц зорилго нь шүүгчийн ашиг сонирхлыг хамгаалахад орших ба уг байгууллага нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.	2.3	Санал нийлэхгүй байна 40% Санал нийлж байна 5% Хэлж мэдэхгүй 40%	Тэнцээгүй
Шүүхийн шийдвэрт төрийн эрх мэдлийн бусад салаа мөчир хийгээд бусад төрийн албан тушаалтны зүгээс нөлөөлөх явдал гардаггүй.	2.5	Санал нийлэхгүй байна 43% Санал нийлж байна 19% Хэлж мэдэхгүй 38%	Тэнцээгүй

мэргэжилтний дөнгөж 19 хувь нь “Шүүхийн шийдвэрт төрийн эрх мэдлийн бусад салаа мөчир хийгээд бусад төрийн албан тушаалтны зүгээс нөлөөлөх явдал гардаггүй” гэжээ.

Ярилцлага өгсөн мэргэжилтний дунд нийтлэг байгаа зүйл бол төрийн өндөр албан тушаалтнууд (ялангуяа Ерөнхийлөгч) Дээд шүүхийн болон Цэцийн шийдвэрт хүчтэй нөлөөлдэг хэмээн үзэж байгаа явдал юм. Түүгээр үл барам, зарим нь нэрээ нууцлахыг хүсээд өндөр албан тушаалтан шүүгчийн ажилд шууд оролцон эцсийн шийдвэрийг өөрийн хүссэн байдлаар гаргуулж байсан тодорхой тохиолдлыг ярьж байв. Гэхдээ энэ нь төрийн албан тушаалтнууд онцын ач холбогдолгүй хэргүүд дээр ч хөндлөнгөөс оролцоод байдаг гэсэн үг биш ээ. Үнэндээ, ихэнхи хэрэг улс төрийн нөлөөнөөс ангид байдаг нь магад. Харин төрийн албан тушаалтны хувийн, бизнесийн, улс төрийн ашиг сонирхол хөндөгдөөд ирэхээр байдал өөр болдог аж.

Шүүх хуулиараа хараат бус, бие даасан байх ёстой боловч шүүхийн шийдвэрт улс төрийн нөлөө орж байгаа байдлаас харахад хууль, амьдрал хоёр хол зөрүүтэй байна. Үүнээс дүгнэхэд шүүхийн үйл ажиллагааны талаарх хуульд заасан хэм хэмжээ, бүтэц зохион байгуулалт нь албан бус институцлэгдсэн хэм хэмжээ, хэвшил болсон зүйлтэй харьцуулахад ач холбогдол багатай байна. Тэдгээр албан бус хэм хэмжээ шүүхийн бие даасан, хараат бус байх зарчимтай зөрчилдөөд ирэхээр бүр хурцаар илэрч байна.

Ямартай ч Монголд харьцангуй түгээмэл байгаа ийм нэг институцлэгдсэн хэм хэмжээ бол клиентелизм юм. Клиентелизм гэдэг нь “хоёр хүний хооронд үүссэн найз нөхдийн онцгой холбоо бөгөөд голдуу тодорхой зорилгод чиглэсэн байх ба нийгэм, эдийн засгийн (эсвэл улс төрийн) хувьд дээгүүр зиндааны нэг этгээд (патрон, ивээн тэтгэгч) нь доогуур зиндааны нөгөөдөө (клиент, дэмжигч) өөрийн нэр нөлөө, боломж бололцоог ашиглан хангамж, хамгаалалт үзүүлж байхад клиент нь мөн хариуд нь ивээн тэтгэгчдээ өөрийн биеэр үйлчлэх зэргээр ерөнхий дэмжлэг, туслалцаа үзүүлдэг үзэгдэл юм.”

Тэтгэгч, дэмжигчийн холбоо нь хоёрхон хүнээр тогтохгүй олон хүнийг хамарч болох тэдгээр нь хэд хэдэн шат дамжлага үүсгэж, улмаар нэгэн пирамид болсноор уг пирамидын орой дээр болон ёроолд нь сууж байгаа этгээдээс бусад нь бүгд нэгэн зэрэг тэтгэгч, дэмжигчийн үүрэг гүйцэтгэнэ. Тэтгэгч, дэмжигчийн холбоонд суурилсан иймэрхүү пирамидыг “нийгмийн солилцооны сүлжээ” гэж нэрлэж болох



ба ийм сүлжээний гишүүн бүрийн үйлдэл нь харилцан адил байх албан бус боловч хатуу тогтсон хэм хэмжээгээр маш хүчтэй хязгаарлагдаж байдаг байна.

Ийм клиентелизм буюу “нийгмийн солилцооны авилгал” Монголд хэр зэрэг газар авсан эсэхээс үл хамааран ямартай ч энэ үзэгдэл нь шүүгчийн томилгоо болон шүүхийн шийдвэрийг бусниулахад тодорхой үүрэг гүйцэтгэж байгаа юм болов уу гэж үзэж байна. Бодит үнэнийг хэт хялбаршуулсан байж магадгүй ч шүүгчийн ажил нь хэн нэгэн өндөр албан тушаалтан (голдуу Ерөнхийлөгч, гэвч бас шүүгчийн томилгоонд чухал үүрэгтэй бусад албан тушаалтан), цаашид өөрийг нь дэмжиж, бас түүнд үнэнчээр зүтгэнэ гэж дотроо амласны хариуд өгдөг тэтгэмж маягийн зүйл болжээ. Төрийн албан тушаалтан нь шүүгчтэй шууд харьцах юмуу эсвэл гуравдагч этгээдээр дамжуулан тодорхой нэг шийдвэр гаргахыг шаардсан тохиолдолд түүнийг нь дагах л болдог аж. Ийм харилцан адил байх зарчим нь албан бус ч гэлээ тухайн хүн маш гүнзгий мэдэрч хүлээж авсан нийгмийн хэм хэмжээ байдаг тул хуулинд заасан шүүхийн эрх мэдэл, бүх насаараа ажиллах эрх зэрэг нь иймэрхүү тохиолдолд шүүхийн хараат бус, бие даасан байдалд маш өчүүхэн мэдрэгдэх төдий л үр нөлөө үзүүлдэг байна.<sup>19</sup>

Клиентелизм Монголд бүх нийгмийг хамран бугшиж тогтсон гэж үзвэл шүүхийн шийдвэр нь тухайн шүүгчийн нийгмийн солилцоонд оролцох янз бүрийн сүлжээний нөлөөнд орох магадлалтай байх ба ялангуяа хэргийн зохигч, эсвэл түүний өмгөөлөгч нь шүүгчтэй сүлжээ үүсгээд ирэхээр бүр ч илэрхий болно. Монголд сайн хуульч гэдэг бол танил талын холбоо сүлбээ ихтэй хуульчийг хэлнэ гэж байнга хэлэлцэх болсны учир энэ.

Харамсалтай нь Монгол дахь шүүхийн шинэтгэл нь шүүхийн томилгоо болон шийдвэр гаргах процесст клиентелизмын гүйцэтгэх үүргийг шууд анхааран авч үзээгүй байна. Түүгээр зогсохгүй уг тогтолцоо нь зарим талаар өөрөө клиентелизмын хортой нөлөөг хязгаарлахаас илүү улам даамжруулж байна.

**Нэгд**, шүүгчийг томилох, өөрчлөх, албан тушаал дэвшүүлэхэд Ерөнхийлөгч тэнцвэргүй их эрх мэдэл эдэлж байх ба энэ бүхэн нь ил тод биш байдаг. Нэгэн мэргэжилтэн хангалттай нотлох баримт гарган хэлснээр шүүгчийн сахилгын арга хэмжээ нь ёс зүйгүй болон мэргэжлийн чадваргүй шүүгчийг зайлуулах гэхээс илүү хэтэрхий хараат бус шүүгчийг шийтгэхэд ашиглагддаг байна.

**Хоёрт**, шүүхийн төсөв болон шүүгчдийн цалин жил болгон хасагдахад бэлэн байдаг. Дээд шүүхийн нэг шүүгчийн хэлснээр “шүүхийн төсөв нь төсвийн талаар шийдвэр гаргах эрхтэй хууль тогтоох болон гүйцэтгэх байгууллагын нөхдүүдтэй сайн харилцаатай байхаас шалтгаалдаг.”

**Гуравт**, Шүүгчийн ёс зүйн дүрэмд шүүхээр орох гэж байгаа хэргийн талаар шүүгч төрийн албан тушаалтан буюу бусад хэрэгт холбогдолгүй этгээдтэй ганцаарчлан

---

<sup>19</sup> Зөвлөлтийн дараахь шилжилтийг ойлгох нь: Далд хуйвалдаан, клиентелизм номондоо Христофер Стеффес тайлбарлахдаа клиентелизм буюу нийгмийн солилцооны авилгал нь бие даасан, хараат бус шүүх зэрэг албан ёсны институц шинээр хөгжихөд ноцтой саад учруулдаг гэжээ:

...Зөвлөлтийн дараахь үед бүх нийгмийг хамарсан клиентелизм болон далд хуйвалдаан зэрэг авилгалын албан бус институц бий болсон нь 1991 оноос өмнөх үеэс үлдсэн зүйл юм. Эдгээр нь төрд ажиллаж байгаа болон жирийн иргэдийн зан үйлийн өөрчлөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүний зэрэгцээ, улс төр, эдийн засгийн албан ёсны институц хөгжихөд саад болдог. Учир нь албан бус институц бий болоод тогтчихсон нөхцөлд албан ёсны институц хөгжихөд бэрхшээл учирна. Шилжиж байгаа улсуудад албан бус хэм хэмжээ нь албан ёсны хэм хэмжээнээс давж үйлчлэх ба ингэснээр эрх зүйт ёс, үндсэн хууль ёс бэхжих орон зай бага байдаг.

## ЧИН ШУДАРГА, ЁС ЗҮЙТЭЙ БАЙХ - ОГТ ХАНГАЛТГҮЙ

Шүүхийн шийдвэр нь хэргийн зохигчид эсвэл бусад сонирхогч талаас өгсөн төлбөр, бэлэг, сэлтийн нөлөөнд ордоггүй.	2.0	Санал нийлэхгүй байна 77% Санал нийлж байна 0% Хэлж мэдэхгүй 23%	Тэнцээгүй
Гэр бүл, нийгэм, бизнес, эсвэл бусад харилцаа нь шүүгчийн үйлдэл эсвэл шийдвэрт нөлөөлдөггүй.	2.0	Санал нийлэхгүй байна 73% Санал нийлж байна 9% Хэлж мэдэхгүй 18%	Тэнцээгүй
Шүүхийн шийдвэрүүдэд зохисгүй байдлын илрэл гардаггүй. Шүүгч гэр бүл, нийгэм, бизнес, эсвэл бусад харилцаа нь ашиг сонирхлын зөрчил үүсгээгүй ч гэсэн тийм зөрчил үүсэхээр харагдаж байвал тухайн хэргийг шүүхээс татгалздаг.	2.3	Санал нийлэхгүй байна 59% Санал нийлж байна 9% Хэлж мэдэхгүй 32%	Тэнцээгүй
Шүүгч аль нэг талыг барьсан харьцаанд ордоггүй. (Шүүгч хэргийн нөгөө талын зохигчид, тэдгээрийн өмгөөлөгчдийг үл байлцуулан хэргийн нэг талтай хэрэгт холбогдох чухал асуудлаар ярилцахаас татгалздаг).	2.0	Санал нийлэхгүй байна 82% Санал нийлж байна 9% Хэлж мэдэхгүй 0%	Тэнцээгүй
Анхан шатны шүүхийн шийдвэр нь тухайн шүүхийн доторх дээд тушаалын шүүгчдийн зүй бус нөлөөнөөс ангид байдаг. (Жишээ нь, тэргүүлэгч, ерөнхий шүүгч, Дээд шүүхийн шүүгч гэх мэт).	2.3	Санал нийлэхгүй байна 64% Санал нийлж байна 14% Хэлж мэдэхгүй 22%	Тэнцээгүй

хэлэлцэхийг хориглоогүй бөгөөд тэдгээр нь шүүхийн шийдвэр ямар байх талаар өөрийн үзэл бодлыг шүүгчид тулгахад саад байхгүй байна.

ННФ-аас асуулга авсан мэргэжилтний дунд бараг нийтлэг байсан зүйл бол шүүхийн шийдвэрт зүй бус төлбөр, шүүгчийн хувийн сонирхол нөлөөлдөг гэж үзсэн явдал байв. Нэгээс бусад бүх мэргэжилтэн буюу тэдний 77 хувь нь “Шүүхийн шийдвэр нь хэргийн зохигчид эсвэл бусад сонирхогч талаас өгсөн төлбөр, бэлэг, сэлтийн нөлөөнд ордоггүй” гэдэгтэй санал нийлээгүй. Тэдний дөнгөж 9 хувь нь санал нийлж байхад 73 хувь нь “Гэр бүл, нийгэм, бизнес, эсвэл бусад харилцаа нь шүүгчийн үйлдэл эсвэл шийдвэрт нөлөөлдөггүй” гэдэгтэй санал нийлээгүй.

Дээр дурдсан гэр бүл, нийгэм, бизнесийн сонирхол шүүхийн шийдвэрт нөлөөлж байгаа нь өмнө дурьдсан албан бусаар тогтсон хэм хэмжээ, нийгмийн солилцооны авлигын гүйцэтгэх үүрэгтэй давхцаж байна. Нийгмийн болон гэр бүлийн харилцан адил байх хэм хэмжээ хүмүүсийн толгойд гүнзгий сууж тогтжээ. Тэр нь одоо дөнгөж төлөвшиж байгаа эрх зүйт ёсны хэм хэмжээтэй зөрчилдөж, нийгмээрээ хүлээн зөвшөөрсөн харилцан адил байх албан бус зарчим нь шүүхийн шийдвэрт байнга нөлөөлсөөр байна гэж үзэж болно.

Ялангуяа Монгол шиг жижиг оронд хүмүүсийн хоорондын харилцаа шүүхийн шийдвэрт тодорхой хэмжээгээр нөлөөлсөөр байна гэж үзэж болохоор байна. Харин шүүхийн шийдвэрт “хэргийн зохигчид эсвэл бусад сонирхогч этгээдийн

зүгээс өгсөн төлбөр, бэлэг, сэлт” нөлөөлдөг гэснээс үзвэл хүмүүсийн хоорондын харилцааны уламжлалт нөлөөллөөс даван илэрхий хахуулдах, авлигад автах явдал тодорхой хэмжээнд байдаг бөгөөд түүнийг соёлын хүрээнд засаж залруулах боломжгүй гэдгийг харуулж байна. Ийм авлига нь шүүгч талууд, түүний өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр нэг тал, түүний өмгөөлөгчтэй ганцаарчлан уулздаг практикаас юуны өмнө болж байна.

Шүүгчдийн дунд бодитой оршин байгаа эсвэл хүмүүст байна гэж ойлгогдож байгаа авлига нь Монгол эрх зүйт ёс, ардчилал хөгжихөд гүн гүнзгий саад тотгор учруулж байна. Шүүхийн авлига нь иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхээ эдлэх боломжийг хааж, хуулийн өмнө эрх тэгш байх зарчмыг алдагдуулж, эцсийн эцэст шүүгчдийн хэрэгжүүлэх ёстой авлигын эсрэг байнгын хүчин чармайлтыг үр дүнгүй болгож байна. Шүүхийн авлига нь албан тушаалаа урвуулан ашиглах явдлыг албан бус “эрх зүйт ёс” болгон хувиргаж байна.<sup>20</sup> Өөрөөр хэлбэл, шүүхийн тогтолцоон дахь авлигыг устгах нь эрх зүйт ёсыг тогтооход хамгийн чухал, зайлшгүй хэрэгжүүлбэл зохих алхам болоод байна. Иймээс ч, ННФ-ын ярилцлага авсан мэргэжилтнүүд энэ сэдэв дахин давтагдаж байсан бөгөөд тэд шүүхийн авлига хаа сайгүй болсон гэдгийг хэлээд нэрээ нууцлахыг хүсээд шүүгчид шийдвэрээ хувийн болон гэр бүлийн ашиг сонирхлоор сольсон тохиолдлыг олон жишээгээр нотолж байв.

Харамсалтай нь, олон улсын томоохон байгууллагын аль нь ч Монгол дахь шүүхийн шинэтгэлийг санхүүжүүлж, дэмжсэн мөртлөө авлигын асуудлыг шууд авч үзээгүй байна. Тэр ч бүү хэл, хандивлагчдын санхүүжүүлж байгаа нэгэн төслийн дээд албаны хүн ярилцах үедээ Монголд авлига ерөөсөө асуудал биш гэж хэлж байв.<sup>21</sup> Үүнийг давхар батлах мэт Дээд шүүхийн шүүгчид мөн л авлигыг үгүйсгэж, нэг нь шүүхийн авлига байна гэсэн хий хардалт хэвлэлээр хариуцлагагүй цацагдаж байгааг шүүмжлээд, харин асуудал нь Монголд “хэвлэлийн эрх чөлөө хэрээс хэтэрсэнд оршиж байна” гэв. Бас нэг шүүгч шүүхийн авлига байна гэсэн хардалт нь мэргэжлийн чадвар мөхөс өмгөөлөгчид өөрсдийн дутагдлыг нуухын тулд шүүгчдийг хахуул авдаг мэтээр буруутган ярьдагаас болж байна гэв. Шүүгчид хахууль авдаг уу гэж асуухад Дээд шүүхийн тэр шүүгч инээмсэглээд, ингэж хариулав: Танай Америкт ярьдагаар нотолж чадаагүй л бол авлига байхгүй л гэсэн үг. Шүүхийн авлигыг мэдсээр атлаа мэдээгүй дүр эсгэж байгаа нь Монголд шүүхийн шинэтгэл амжилтгүй болоход нөлөөлж байгаа гол хүчин зүйл болж байна.<sup>22</sup>

---

<sup>20</sup> Дэлхий дээрх авлига судалгааны 2007 оны тайланг үз. Transparency International, p. xxi (Cambridge University Press) Тэнд тэмдэглэн хэлснээр шүүх авилгалд автахын хор уршгийг тоочоод барахгүй. Үндэстэн дамнасан гэмт хэрэг, алан хядлагатай олон улсын хэмжээнд хамтран тэмцэх боломжийг бууруулна. Худалдаа, эдийн засгийн өсөлт, хүний хөгжлийг уналтад оруулж, хамгийн чухал нь иргэд өөр хоорондоо болон эрх баригчидтай маргаж тэмцэх үед аль нэг талыг барилгүй маргааныг шийдэх боломжгүй болгоно. Үүнээс болж авилгалд идэгдсэн шүүх шударга бус шийдвэрт дургүйцсэн өшөө хорслыг өдөөж нийгмийг хагалан бутаргаж байдаг. Авлига, хээл хахуулд идэгдэн оршин тогтнох үндэсгүй болмогц шүүх засагд итгэх итгэлийг үгүй хийж эрх мэдлийн хамгийн дээд оргилоос эхлээд төрийн бүх шатанд авлига газар авах нөхцлийг бүрдүүлдэг. Ингээд авлигыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй гэсэн ойлголтыг хүмүүст төрүүлдэг.

<sup>21</sup> Энэ хүн шүүхэд арван жил ажиллахдаа авлига юм уу, зүй бус нөлөөллийн тухай баримт олж үзээгүй гэв.

<sup>22</sup> Нөгөө талаас, Монголын шүүхийн авлига нь Монголын нийгмийг бүхэлд нь хамарч, ямар түвшинд байгааг харуулна. Өөрөөр хэлбэл, шүүхийн шинэтгэл хоосон орон зайд бус харин төрийн бүх түвшин дэх авлигыг устгахад чиглэсэн өргөн хүрээтэй, шийдэмгий арга хэмжээний нэг хэсэг байх ёстой. Дээрхийг үз. (“Шүүхийн тогтолцоо нь тухайн нийгмээсээ ургаж гарсан байдаг. Тухайн нийгэм дэх авлигын ерөнхий түвшин шүүхийн авлигын түвшинтэй ойр шүтэлцээтэй байдаг. Үүнээс үзэхэд шүүхийн тогтолцоог эрүүлжүүлэх нь авлигын эсрэг тэмцэхэд гол үүрэгтэй. Гэхдээ шүүхийн тогтолцооны чанар болон шүүгч нарын албан тушаалаа хувийн ашгийн төлөө ашиглах гэсэн санаа агуулж байгаа нь нийгэм дэх авлигад хандах ерөнхий хандлагыг илэрхийлнэ.”)

## ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ – ХАНГАЛТГҮЙ

Ёс зүйн дүрэмд ашиг сонирхлын зөрчилтэй бол шүүгч хэрэг шүүх тохиолдлыг тодорхой зааж, хориглосон.	2.5	Санал нийлэхгүй байна 55% Санал нийлж байна 23% Хэлж мэдэхгүй 23%	Тэнцээгүй
Ёс зүйн дүрэмд шүүгч хэргийн талуудтай ганцаарчлан холбоо тогтоохыг хориглосон.	2.3	Санал нийлэхгүй байна 53% Санал нийлж байна 14% Хэлж мэдэхгүй 33%	Тэнцээгүй
Ёс зүйн дүрэмд шүүгч улс төрийн ажиллагаанд оролцохыг хориглосон.	3.0	Санал нийлэхгүй байна 32% Санал нийлж байна 32% Хэлж мэдэхгүй 36%	Хэлж мэдэхгүй

Шүүхийн авлига бодитой оршиж байгаа болон авлига байна гэсэн хардалт нь шүүгчийн ёс зүйн дүрэм бүрхэг, хүчин мөхөс байгаатай холбоотой. Мөн шүүгчийн зүй бус үйлдлийг бүрэн дүүрэн тодорхойлж, хориглоогүй төдийгүй, зүй бус үйлдлийн илрэлээс сэргийлэх тухай заагаагүй нь нөлөөлж байна. Жишээ нь, шүүгч болон талуудын хооронд ганцаарчилсан харилцаа холбоо үүсэхийг шүүгчийн ёс зүйн дүрэмд хориглоогүй байна. Судалгаанд хамрагдсан мэргэжилтний 82 хувь нь шүүгчид үнэхээр хэргийн талууд болон тэдний өмгөөлөгчтэй хувиараа уулзах явдал байдаг гэдэгтэй санал нийлжээ. Ганцаарчлан уулзахдаа ямар асуудлаар ярьдаг эсэхээс үл хамааран ийм үйлдэл нь авлигад өртөх нөхцлийг бүрдүүлж, шүүхийг хардахад хүргэж байгаа юм. Шүүгчийн ёс зүйн дүрмийн заалтууд нэн бүрхэг бөгөөд шүүгч ашиг сонирхлын зөрчилтэй хэрэг шүүхийг хориглоогүй байна. Шүүгчид гэр бүл, нийгэм, бизнесийн харилцаанаас үүдэлтэй ашиг сонирхлын зөрчилтэй байсан атлаа хэргийг шүүх явдал байнга гардаг. Шүүхийн шийдвэр ийм зөрчлөөс болж нөлөөнд автдаг эсэхээс үл хамааран гаднаасаа харахад зүй бус байдлыг үүсгэн, иргэдийн дунд шүүхийн авлигын талаар хардалт бий болох нөхцлийг бүрдүүлж байна. Олон тохиолдолд ийм зөрчил шүүхийн эцсийн шийдвэрт нөлөөлдөг болохыг хөгтэй жишээ, баримт нотолж байна.

Шүүгчийн ёс зүйн дүрэм нь хүч мөхөс учраас “хориглоогүй” зүй бус үйлдэл гаргах үлэмж их орон зай үлдээсэн байна. Харин илэрхий хориглосон үйлдэл, тухайлбал хахууль авах зэрэг үйлдэл гаргахад хариуцлага тооцох нь ховор.

Монголд Шүүхийн сахилгын хороо байуулагдсан боловч олон мэргэжилтний үзэж байгаагаар Сахилгын хороо хахуульд зуучлах, хахууль авах зэргээр эрх мэдлээ урвуулан ашиглах эсвэл өөр ямар нэг хэлбэрээр хувийн сонирхлоо хангаж байгаа шүүгчийг биш харин хэтэрхий хараат бус шүүгчийг шийтгэх гол хэрэгсэл болжээ. Жишээ нь, Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн шүүгчид баг болон ажиллах нь зүйтэй гэснээс зөрж, шүүгч хараат бусаар шийдвэрээ гаргах ёстой гэж олон нийтийн өмнө хэлснийхээ төлөө нэгэн шүүгч Сахилгын хороогоор орсон байна.

Түүнчлэн ярилцлага болон санал асуулгын аль алинд шүүгчийн зүй бус үйлдлийг мөрдөн шалгахад улс төрийн нөлөөлөл, албан тушаалаа ашиглах явдал гарч байгаад сэтгэл зовниж байгаагаар мэргэжилтнүүд илэрхийлсэн байна. Сахилгын хорооны үйл ажиллагаа нь ил тод биш учраас үүнийг баталж нотлоход

## ХАРИУЦЛАГА – ХАНГАЛТГҮЙ

Шүүгч, өмгөөлөгч, иргэн тодорхой шүүгчийн зүй бус үйлдлийн талаар гомдол гаргах журам байдаг бөгөөд тэр нь хэрэгжих боломжтой.	2.8	Санал нийлэхгүй байна 41% Санал нийлж байна 27% Хэлж мэдэхгүй 32%	Тэнцээгүй
Шүүгчийн зүй бус үйлдлийн талаар гарсан гомдлыг бүрэн дүүрэн мөрдөн шалгадаг.	2.5	Санал нийлэхгүй байна 46% Санал нийлж байна 23% Хэлж мэдэхгүй 31%	Тэнцээгүй
Шүүгчийн зүй бус үйлдлийн талаарх гомдлыг мөрдөн шалгахад төрийн бусад байгууллага хөндлөнгөөс оролцдоггүй.	2.7	Санал нийлэхгүй байна 32% Санал нийлж байна 19% Хэлж мэдэхгүй 50%	Тэнцээгүй
Шүүгчийн зүй бус үйлдлийн талаарх мөрдөн шалгах ажиллагаа нь албан бус төлбөр, бэлэг, сэлт, тал тохой татах хэлбэрээр шүүгчид болон сонирхогч талуудын зүгээс нөлөөнд автдаггүй.	2.7	Санал нийлэхгүй байна 41% Санал нийлж байна 18% Хэлж мэдэхгүй 41%	Тэнцээгүй

хүндрэлтэй. Харин хорооноос гаргасан статистик тоо баримтаас үзвэл шүүгчийн эсрэг гаргасан гомдлыг дийлэнх олонхийг ямар ч арга хэмжээ авалгүй, тайлбар үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгодог байна. Жишээ нь, 2003-аас 2005 оны хооронд Улаанбаатар хотоос гарсан 28 гомдлын 22-ыг ийм байдлаар хэрэгсэхгүй болгожээ. Нөгөө зургаан гомдол нь чухам юу болсон талаар нийтэд мэдээлээгүй байна. Олон нийтийн өмнө ил тод биш эсвэл хөндлөнгийн шалгалт хийгдээгүй болохоор хэрэгсэхгүй болгосон гомдлын тоо өндөр байгааг үнэхээр шүүгчийн зүй бус үйлдэл гарахгүй байгаатай холбож үзэх үү эсвэл гомдлын барагдуулалт хангалтгүй байна гэж үзэх үү гэж хардахаас өөр аргагүй байдалд орж байна. Энэ нь шүүхийн дотор авлига байна гэж хардах боломжийг нээж байна.

Түүнээс гадна Монголын хууль авлигын талаар мэдээлэл өгсөн хувь хүнд хамгаалалт бий болгоогүй учраас шүүгчид авлига авсан тохиолдолд авлига өгсөн этгээд нь уг шүүгчийг холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдвэл өөрөө гэмт хэрэгт холбогдон, яллагдах эрсдэлтэй байгаа юм. Мөн Монголд хүнийг гүтгэн, нэр хүндийг нь гутаахын эсрэг хуулийг буруугаар ашиглаж, авлигын талаар мэдээлэл өгсөн хүний амыг таглах явдал нэмэгдэж байгаа (авлигын талаар тодорхой мэдээлэл өгсөн хэд хэдэн хүнийг шоронд хорьсон дуулиант хэргүүд гарсан) болохоор өөрөө тухайн авлигын хэрэгт холбогдолгүй байсан ч мэдээлэл өгөх хүн цөөхөн байна.

Шүүхийн авлигын талаар мэдээлэх гэсэн хүнийг дуугүй болгож байгаа нь Монголд авлига тогтолцоог бүхэлд нь хамарч, хариуцлагын механизм байхгүй байгааг

<sup>23</sup> Assessment Report of the Strategic Plan for Justice System of Mongolia, Judicial Reform Program, USAID (2006) [Шүүхийн шинэтгэлийн стратеги төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ].

<sup>24</sup> Төрийн байгууллагад ажилладаг нэг хүн хэрвээ шүүхийн авлигын судалгаа хийгээд, өмгөөлөгчдийн санал асуулгаар хэн нэгэн шүүгчийг хамгийн их авлига авдаг гээд гаргаад ирвэл судалгаа хийсэн хүн өөрөө хүн гүтгэсэн хэрэгт холбогдож магадгүй гэж сануулав.

## ИЛ ТОД БАЙДАЛ – ОГТ ХАНГАЛТГҮЙ

Дээд шүүх болон давж заалдах шатны чухал шийдвэрүүдийг эрдэмтэд судлаачид шүүн хэлэлцдэг.	2.3	Санал нийлэхгүй байна 68% Санал нийлж байна 19% Хэлж мэдэхгүй 13%	Тэнцээгүй
Дээд шүүхийн болон давж заалдах шатны чухал шийдвэрүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийт иргэд шүүн хэлэлцдэг.	2.7	Санал нийлэхгүй байна 50% Санал нийлж байна 41% Хэлж мэдэхгүй 9%	Тэнцээгүй
Шүүгчдэд хэрэг хуваарилахдаа сугалааны аргаар болон тухайн шүүгчийн туршлага, мэргэшилд үндэслэн хуваарилдаг	2.6	Санал нийлэхгүй байна 41% Санал нийлж байна 18% Хэлж мэдэхгүй 41%	Тэнцээгүй
Шүүх хурал иргэд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд нээлттэй байдаг.	2.5	Санал нийлэхгүй байна 59% Санал нийлж байна 23% Хэлж мэдэхгүй 18%	Тэнцээгүй
Шүүх хурлын танхим нь иргэд, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг багтаах хангалттай зайтай.	2.0	Санал нийлэхгүй байна 82% Санал нийлж байна 9% Хэлж мэдэхгүй 9%	Тэнцээгүй
Шүүхийн шийдвэр нийтийн хүртээл болдог.	2.5	Санал нийлэхгүй байна 68% Санал нийлж байна 23% Хэлж мэдэхгүй 5%	Тэнцээгүй
Дээд шүүхийн болон давж заалдах шатны чухал шийдвэрүүд хэвлэгдэн нийтлэгддэг.	2.2	Санал нийлэхгүй байна 86% Санал нийлж байна 14% Хэлж мэдэхгүй 0%	Тэнцээгүй
Хурлын тэмдэглэл эсвэл бусад найдвартай аргаар шүүх хурлын танхимд болж байгаа ажиллагааг бэхжүүлэн авдаг бөгөөд уг мэдээллийг хэргийн зохигчид болон тэдний өмгөөлөгч нар авч болдог.	3.5	Санал нийлэхгүй байна 14% Санал нийлж байна 69% Хэлж мэдэхгүй 17%	Тэнцсэн
Хурлын тэмдэглэл эсвэл бусад найдвартай аргаар шүүх хурлын танхимд болж байгаа ажиллагааг бэхжүүлэн авдаг бөгөөд уг мэдээллийг хэвлэл мэдээлэл болон иргэд авч болдог.	2.2	Санал нийлэхгүй байна 63% Санал нийлж байна 14% Хэлж мэдэхгүй 23%	Тэнцээгүй
Шүүхээр үйлчлүүлэгчид хэргийнхээ явцын талаар мэдээлэл олж авахад төвөггүй байдаг.	1.9	Санал нийлэхгүй байна 82% Санал нийлж байна 9% Хэлж мэдэхгүй 9%	Тэнцээгүй
Тухайн үед мөрдөгдөж байгаа хуулийг нийтэд тарааж, индексжүүлсэн. (Улсын хэмжээнд нийтээр хүлээн зөвшөөрсөн тухайн үед мөрдөгдөж байгаа дотоодын хууль, хуулийн шинжлэх ухааны тайлбар сэлтийг индексжүүлэх систем байдаг бөгөөд хуульд орсон өөрчлөлтийг илрүүлэн, цэгцэлж байдаг).	2.7	Санал нийлэхгүй байна 45% Санал нийлж байна 41% Хэлж мэдэхгүй 14%	Тэнцээгүй

харуулж байна. Байдал ийм байхад шүүхийн шинэтгэлийн зорилго нь шүүхийг авлигаас чөлөөлж, шударга ёсыг сахиулдаг, иргэд түүний төлөө ханддаг газар болгох ёстой байтал Монгол дахь шүүхийн шинэтгэл шүүгчидтэй хариуцлага тооцохын оронд шүүхийн дэд бүтцийг сайжруулахад ихээхэн анхаарч иржээ.

Монголын шүүхэд авлига газар авсан эсвэл авлигын талаар хардалт их байгааг тайлбарлах бас нэг хүчин зүйл бол шүүхүүд шийдвэрээ чухам яаж гаргадаг нь огтоос ил тод биш байгаа явдал юм. Ил тод байдал дутагдахаар шүүгчид зүй бус үйлдлээ халхавчлах боломж олгох ба авлига байхгүй байсан ч хүмүүс байна хэмээн хардахад хүргэж байна. Монголд авлига тогтолцоогоо бүхэлд нь хамарсан учраас шийдвэр нь илт зөв л биш бол шүүгч нь хахууль авчихлаа хэмээн ялагдсан тал хэлэхэд түүнийг бараг л буруутгах арга байхгүй. Авлигын талаарх хардалтыг бууруулах цорын ганц арга зам бол туйлын ил тод байдлыг хангахын төлөө ажиллах явдал юм. Харамсалтай нь Монголд шүүхийн шинэтгэл хийж байгаа байгууллагууд ил тод байдлыг чухал асуудлын тоонд оруулаагүй. Үүний нотолгоо нь гэвэл:

- Мэргэжилтний дөнгөж 18 хувь нь шүүгчид хэргийг хуваарилахдаа ил тод, бодитой журам баримталдаг гэдэгтэй санал нийлжээ.
- Хэдийгээр шүүх хурлын ажиллагаа нийтэд зарчмын хувьд нээлттэй боловч практик дээр шүүхийн танхим нь зай багатайгаас иргэд багтахгүй, шүүгч болон түүний туслах нь иргэдийг хуралд оруулахгүй байх явдал байнга гардаг.<sup>25</sup>
- Дээд шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн чухал шийдвэрийг нийтлэх нь ховор бөгөөд нийтэлсэн үедээ нийтэд тараадаггүй.
- Анхан шатны шүүхийн шийдвэр ерөөс нийтлэгддэггүй бөгөөд өөр ямар нэг хэлбэрээр нийтийн хүртээл болдоггүй.
- Анхан шатны шүүх хурлын ажиллагааны тэмдэглэл хангалтгүй. Анхан шатны шүүх хурлыг баримтжуулж үлддэг цорын ганц зүйл нь шүүх өөрийн шийдвэрт талуудын тайлбарыг хураангуйлан оруулсан хэсэг юм. Гэвч энэ нь давж заалдах шатанд ашиглая гэхэд сайндаа хагас дутуу, заримдаа бүр гуйвуулсан мэдээллийг ч агуулсан байдаг.
- Шүүх хурлын талаарх ийм хагас дутуу хураангуй мэдээлэл нь хүртэл хэвлэл мэдээлэл, нийт иргэний хүртээл болдоггүй.
- Мэргэжилтний 82 хувь нь шүүхээр үйлчлүүлэгчид хэргийн явцын талаар мэдээлэл авахад амаргүй байдаг гэж үзжээ.<sup>26</sup>
- Анхан шатны шүүх зүгээр л шийдвэрээ уншиж танилцуулаад шийдвэрийнхээ цаад үндэслэгээг хэргийн нотлох баримт, хэрэглэсэн

---

<sup>25</sup> Отгонтэнгэр их сургуулийн Шүүхийн ажиглалт хөтөлбөрийн эцсийн тайлан (2005).

<sup>26</sup> АНУ-ын ОУХА шүүхийн байранд олон нийтэд зориулан компьютер тавьж өгснийгөө Шүүхийн шинэтгэлд том ахиц гарсаны баримт гэж ярьдаг боловч байдал өөр байна. See Assessment Report of the Strategic Plan for Justice System of Mongolia, Judicial Reform Program, USAID (2006). Амьдрал дээр олон нийтэд зориулсан компьютер нь тогтмол ажилладаггүй, эвдсэн эсвэл шүүхээр үйлчлүүлэгчид ашиглах боломжгүй байдаг. Отгонтэнгэр их сургуулийн Шүүхийн ажиглалт хөтөлбөрийн эцсийн тайлан (2005).

хуульд тулгуурлан тайлбарлах нь ховор байдаг учраас шүүхийн шийдвэр юунд үндэслэж гарсан талаар таг дуугүй, юу ч болоогүй юм шиг хандах байдал руу оруулж байна.

- Дээд шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн чухал гэсэн шийдвэрийг эрдэмтэд судлаачид шүүмжлэн хэлэлцэх нь ховор байдаг нь хайнга, бүрхэг шийдвэр гарсаар байгаагийн нэг шалтгаан бөгөөд алдаатай шийдвэр анзаарагдахгүй өнгөрөхөд хүргэж, хариуцлага тооцох аргагүй байдлыг үүсгэж байна.<sup>27</sup>

Олон улсын хандивлагчид шүүхийн шинэтгэлийн төсөлдөө хэргийн менежментийг сайжруулах, компьютер ашиглалтыг нэмэгдүүлэх, (хэргийг хэрхэн шийдсэн биш хэргийн хугацааг баримталсан байдлаар нь) шүүгчийн ажлыг дүгнэх зэргээр шүүхийн шуурхай ажиллагааг сайжруулахад анхаарч иржээ. Иймд ННФ шуурхай байдлыг судалгааныхаа чухал асуудлын тоонд оруулаагүй болно. Гэхдээ мэргэжилтний дөнгөж 27 хувь нь “Шүүхийн тогтолцоонд хэргийг боломжийн хугацаанд шуурхай шийдэх нөхцлийг бүрдүүлэхийн тулд хэргийг хүлээн авч бүртгэх, хэргийн явцыг хянах үр дүнтэй, хүртээмжтэй тогтолцоо үйлчилдэг” гэдэгтэй санал нийлсэн байхад 50 хувь нь санал нийлээгүй байна. Мөн 54 хувь нь “Хэрэг хянан шийдвэрлэх процессийн хэм хэмжээ нь стандартчилагдсан, хэргийн янз бүрийн шатанд тавигдах хугацааны хязгаарлалт байдаг” гэдэгтэй санал нийлээгүй байна. Эндээс үзэхэд шүүхийн шуурхай ажиллагааг чухалчилсан нь ор үндэсгүй зүйл биш болох нь харагдаж байна.

Шүүгч нарт зориулсан сургалт явагдаж энэ чиглэлд үлэмж дэвшил гарсан ч гэсэн судалгаанд хамрагдсан мэргэжилтний нэлээд олонхи нь шүүгчид процессийн хэм хэмжээг биелүүлдэггүй, нотолгооны журмыг дагаж мөрддөггүй, хууль зүйн стандарт, дүрмийг урьдаас тооцоолох боломжтой байдлаар хэрэглэдэггүй гэж үзсэн байна. Шүүхийн шийдвэр нь урьдаас тооцоолох боломж өгдөггүй, нэг мөр биш байдаг нь давж заалдах шатанд шийдсэн хэргийн дотроос 80 хүртэл хувь нь анхан шатны шийдвэрийг хүчингүй болгосон шийдвэр байдгаас харагдаж

## ШУУРХАЙ БАЙДАЛ – ХАНГАЛТГҮЙ

Шүүхийн тогтолцоонд хэргийг боломжийн хугацаанд шуурхай шийдэх нөхцлийг бүрдүүлэхийн тулд хэргийг хүлээн авч бүртгэх, хэргийн явцыг хянах үр дүнтэй, хүртээмжтэй тогтолцоо үйлчилдэг.	2.7	Санал нийлэхгүй байна 50% Санал нийлж байна 27% Хэлж мэдэхгүй 23%	Тэнцээгүй
Хэрэг хянан шийдвэрлэх процессийн хэм хэмжээ нь стандартчилагдсан, хэргийн янз бүрийн шатанд тавигдах хугацааны хязгаарлалт байдаг.	2.4	Санал нийлэхгүй байна 54% Санал нийлж байна 32% Хэлж мэдэхгүй 14%	Тэнцээгүй

<sup>27</sup> Нэг мэргэжилтэн эрдэмтэд шүүхийн шийдвэрийг шүүмжлэн хэлэлцдэггүйн шалтгаан нь тэд өөрсдөө цалин бага учраас өмгөөлөл хийдэг бөгөөд хэрэв тэд шүүхийг шүүмжлэх юм бол өөрсдийнх нь амьдралд халгаатай болно гэж тайлбарлав. Мөн ихэнхи хуульч эрдэмтэд “шүүгчдийн халаасанд орсон” гэв.



## УРЬДААС ТООЦООЛОХ БОЛОМЖ – ОГТ ХАНГАЛТГҮЙ

Шүүгч процессийн хэм хэмжээг дагаж мөрдөн, албадан биелүүлдэг.	2.2	Санал нийлэхгүй байна 68% Санал нийлж байна 14% Хэлж мэдэхгүй 18%	Тэнцээгүй
Шүүгч ямар нотлох баримтыг хүлээн авч болох, болохгүйг заасан нотолгооны журам үйлчилдэг.	2.4	Санал нийлэхгүй байна 63% Санал нийлж байна 23% Хэлж мэдэхгүй 14%	Тэнцээгүй
Шүүгч хүчин төгөлдөр байгаа нотолгооны журмыг дагаж мөрддөг. (Шүүгч хэрэгт ач холбогдолгүй нотлох баримтыг хүлээн авах буюу хэрэгт ач холбогдолтой нотлох баримтыг авалгүй үлдээх явдал гаргадаггүй).	2.3	Санал нийлэхгүй байна 63% Санал нийлж байна 23% Хэлж мэдэхгүй 14%	Тэнцээгүй
Хууль зүйн үндэслэл бүхий тайлбарыг үнэлж үзэх шүүхийн стандарт байдаг бөгөөд урьдаас тооцоолох боломжтой байдлаар уг стандартыг хэрэглэдэг.	2.1	Санал нийлэхгүй байна 64% Санал нийлж байна 14% Хэлж мэдэхгүй 14%	Тэнцээгүй

## МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХИЙН БУС АРГА ХЭЛБЭР – ХАНГАЛТГҮЙ

Шүүхээс өмнө шатанд хэрэг маргааныг шийдвэрлэх явдлыг дэмждэг боловч хүчилдэггүй.	3.2	Санал нийлэхгүй байна 28% Санал нийлж байна 58% Хэлж мэдэхгүй 14%	Тэнцсэн
Зуучлал, арбитр зэрэг маргаан шийдвэрлэх шүүхийн бус арга хэлбэр бий болж хэвшсэн бөгөөд шүүхээс гадуур хэрэг маргааныг шийдвэрлэх найдвартай боломж олгодог.	2.5	Санал нийлэхгүй байна 54% Санал нийлж байна 23% Хэлж мэдэхгүй 13%	Тэнцээгүй

байна.<sup>28</sup> Энэ үзүүлэлт нь анхан шатны шүүхийн шүүгч нар нэг бол хуулийн суурь боловсрол нимгэн, нэг бол үргэлжилсэн сургалтад муу хамрагддаг, нэг бол хэрэг шийдэхдээ гадны хүчин зүйл (улс төрийн нөлөөлөл, хахууль авах)-д үндэслэдэг гэдгийг харуулж байгаа үнэмшилтэй баримт юм. Шүүхийн шийдвэр урьдаас тооцоолох боломж өгдөггүй бөгөөд ер нь шийдвэрээ дур мэдэн гаргадаг хандлага ажиглагдаж байгаа нь эрх зүйт ёсонд хүнд цохилт өгч, нийгмийн шударга ёс, эдийн засгийн үр ашигт байдлыг хангахад шүүхийн гүйцэтгэх үүрэг эргэлзээнд ороход хүргэж байна.

Монгол Улс шүүхийн бус маргаан шийдвэрлэх хэлбэрийг хөгжүүлэх талаар хэд хэдэн нааштай алхам хийжээ. Юуны өмнө, шүүхээс өмнөх шатанд маргааныг шийдвэрлэхийг албадах бус, харин сонирхлыг дэмжих зорилгоор маргаанаа

<sup>28</sup> Иргэний хэргийн дөнгөж 3% нь давж заалдах шатанд шилждэг. Дээд шүүхийн шүүгч Л. Бямбаатай ярилцахад давж заалдах шатанд доод шатны шийдвэрийг хүчингүй болгох нь элбэг байхад яагаад давж заалдах сонирхол бага байна вэ гэвэл санхүүгийн боломжгүй, давж заалдах эрхээ мэддэггүй, эсвэл зөвхөн давж заалдах шатны шүүхийн шүүгчид нөлөөлөх танил талын сүлбээтэй хэсэг нь давж заалддаг гэсэн тайлбар өгөв.

шийдвэрлэсэн тохиолдолд талуудаас авах бүртгэлийн хураамжийг тал хувиар бууруулжээ. Мөн сайн дураар, гэхдээ заавал биелүүлэх шийдвэр гаргах эрхтэй арбитрын журмаар иргэний хэрэг маргааныг шийдвэрлэх боломжийг хуулиар олгосон байна. Худалдаа аж үйлдвэрийн танхимын байнгын арбитрын шүүх юмуу талууд өөрсдөө байгуулсан арбитрын түр шүүхээр маргаанаа таслуулах боломжтой. Мөн 2006 оны 5 сард 9 өмгөөлөгчийн бүрэлдэхүүнтэй эвлэрүүлэн зуучлах төвийг JICA-ын тусламжтайгаар байгуулсан.

Гэвч зарим мэргэжилтэн эвлэрүүлэн зуучлах төвийн ажиллагааг чанарын үзүүлэлтээр доогуур үнэлсэн байхад нөгөө хэсэг нь тус төв байдаг гэдгийг мэдэхгүй, зуучлал гэж юу болохыг ч мэдэхгүй байв. Цаашилбал, Монголын хуулиар зуучлалыг маргаан шийдвэрлэх нэг арга хэмээн албан ёсоор зөвшөөрөөгүй бөгөөд шүүхийн дэргэд зуучлалын үйлчилгээ үзүүлэх хөтөлбөр байхгүй, шүүгчид хэргийн талуудад шүүхээр орохоос өмнө зуучлалыг ашиглан эвлэрэх оролдлого хийхийг санал болгох эрх хэмжээ байхгүй байна.

## САНАЛ ЗӨВЛӨМЖ

Санал, зөвлөмж нь энэхүү тайланд хөндсөн гол гол асуудалд анхаарал хандуулахад чиглэсэн болно. Эдгээр санал зөвлөмж нь цаашид ярьж хэлэлцэх эхлэлийг тавих зорилготой бөгөөд бүх асуудлыг бүрэн хамарсан гэж ойлгож болохгүй юм. Харин зохиогчийн үзэж буйгаар авлигаас ангид, шуурхай ажиллагаатай, бие даасан, хараат бус шүүхийг тогтоох зорилгод хүрэхэд ямар төрлийн арга хэмжээ шаардлагатай вэ гэсэн асуултад хариулт өгөхөд чиглэв. Мөн эдгээр санал зөвлөмж нь шүүхийн шинэтгэл ил тод байдлыг хангаж, хариуцлагын тогтолцоог бүрдүүлж, авлигатай тууштай тэмцэж, устгахад чиглэх ёстой бөгөөд тэгж эс чадваас амжилт олохгүй гэдэгт бат итгэсэн зохиогчийн итгэлээс үүдэлтэй.

Санал болгож байгаа шинэтгэлийн ихэнх нь Нээлттэй Нийгэм Форум (ННФ) дангаар хэрэгжүүлэх боломжгүй, харин нийтээр зөвшилцөлд хүрч, улс төрийн хүсэл зориг гаргаж байж хэрэгжих боломжтой юм. Тэрхүү зөвшилцөл нь үнэхээр хойшлуулшгүй зорилт мөн эсэхийг шүүх эрх мэдэл бүхэлдээ авилгалд автсан уу, үгүй гэдгийг үнэлсэн олон нийтийн үнэлгээнээс л хамаарах ёстой. Шүүхийн авлига бодитой байгаа юу эсвэл энэ нь хардалт уу гэдгийг эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээд (шүүгчдийг өөрсдийг нь оролцуулан) нар зөвшилцөн дүгнэх ёсгүй. Харин шүүхийн тогтолцооны эцсийн зорилго нь олон нийтийн шударга итгэл учраас эрх ашиг нь хөндөгдсөн этгээд тэдэнтэй зөвшилцөх ёстой.

Иймд, эхний санал зөвлөмж бол энэхүү тайланг (хэрэв өөрчлөгдсөн бол тэр хувилбарыг) нийтэлж, тараагаад, эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдүүд тухайлбал, шүүгчдийг урьж оролцуулан цаашид авах арга хэмжээний стратеги боловсруулах явдал юм. Нөгөө талаас шүүхийн шинэтгэлийн явцад эрх ашиг нь хөндөгдөж байгаа гол этгээд нь нийт иргэд гэдгийг санаж байх нь чухал. ННФ зэрэг иргэний нийгмийн байгууллагын үүрэг бол олон түмний эрх ашгийг юу юунаас илүү чухалчлах явдал юм. Энэхүү тайлангийн нэг тулгуур дүгнэлт бол Монгол дахь шүүхийн шинэтгэлийн хүрээнд шийдвэрлэх асуудлыг тодорхойлоход бүрэн бие даасан, хараат бус, худалдагдахаас бүрэн хамгаалагдсан тийм шүүхийн тогтолцоо байгуулах нь өөрсдөд нь ашиггүй гэж үзсэн шүүхийн болон төрийн байгууллага доторх зарим элементүүд оролцсон гэж үзэж байна.

Ийм эсэргүүцэл байгаа учраас ил тод байдал, хариуцлагыг цуцалтгүй хамгаалан тэмцэхийг зөвлөмж болгож байна. Мөн авилгалд автагдахаас сэргийлэх хэд хэдэн арга хэмжээг санал болгож байна. Тухайлбал, ННФ дараахь чиглэлээр ажиллахыг зөвлөж байна.

### ЧАНАР БОЛОН ШҮҮГЧИЙН СУРГАЛТАД ЧИГЛЭСЭН ШИНЭТГЭЛ

1. Шүүгчдийг ажил үүргээ хэрхэн биелүүлж байгаа байдалд нь тогтмол шалгалт хийж байх нь зүйтэй. (Ил тод шүүх: Шүүхийн үйл ажиллагааг

үнэлэх шалгуур<sup>29</sup> гэсэн хавсралт С-г үз) Шалгалтыг шүүгчдийн өмнө хэрэг өмгөөлж байсан Өмгөөлөгчдийн холбооны гишүүдийн дунд нууц санал асуулга явуулах замаар хийвэл зохино. Уг судалгаанд наанадаж шүүгчийн үзэл бодолдоо үнэнч байдал, шударга байдал, зан авир, хуулийн мэдлэг, хууль зүйн үндэслэгээ гаргах чадвар, ажилдаа хариуцлагатай, үнэнч хандаж байгаа байдал, мэргэжлийн ур чадвар зэрэг үзүүлэлтээр шүүгчийг үнэлэх нь зүйтэй (Өмгөөлөгчөөс авах санал асуулгын загварыг Хавсралт С-ийн 43 дахь хуудаснаас үз). Эдгээр тогтмол судалгаагаар шүүгчдийн авсан үнэлгээг олон нийтэд мэдээлж, АНУ-ын Колорадо муж улсын туршлагаар эрэмбэлж жагсаалт гарган нийтэд мэдэгдэж байх хэрэгтэй. Хэрэв үнэлгээг Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн байгууллага, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны бүрэн дэмжлэгийг авсан хараат бус хороо байгуулан хийлгэвэл хамгийн сайн. Хэрэв ийм дэмжлэг авах найдваргүй бол ННФ өөрөө бие даан үнэлгээг хийлгэх хэрэгтэй. ННФ судалгааны үр дүнг мөн өргөн олон нийтэд хүргэвэл зохино. Эдгээр үнэлгээ нь энэхүү тайлангийн үлдэх хэсэгт санал болгосон шинэтгэл шаардлагатай байгааг дахин нотлох болно. Энд санал болгосон шинэтгэлийг одоогийн тогтолцооноос ашиг олж байгаа этгээдүүд хүчтэй эсэргүүцэх нь тодорхой учраас эхний удаагийн үнэлгээг ННФ Өмгөөлөгчдийн холбоотой хамтран хийх нь хамгийн ухаалаг шийдэл болох байх.

2. Шинээр томилогдсон шүүгч нарт тавигдах хамгийн гол шаардлагыг тогтоож өгөх хэрэгтэй. Шүүгчээр ажиллах иргэн наад зах нь хууль зүйн дээд сургууль төгссөн,<sup>30</sup> хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, дор хаяж гурван жил өмгөөлөгчөөр юмуу прокуророор ажилласан байх.
3. Шүүгчдийг сонгохдоо бодит шалгуур тавьж, тухайлбал, төрийн албаны шалгалтад авсан оноог нь үндэслэн хамгийн өндөр оноотой иргэнийг авдаг байх. Жишээ нь, шүүгчийг томилохдоо шүүхэд орон тоо гармагц, төрийн албаны шалгалтаар хамгийн өндөр оноо авсан өргөдөл гаргагчийн нэрийг Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид гаргаж өгсөнөөр тухайн иргэнийг томилохоос Ерөнхийлөгч татгалзах эрхгүй байх хэрэгтэй. Ингэснээр шүүхэд хамгийн шилдэг хүмүүс ажиллаж, одоогийн томилгооны журамд оршиж байгаа нийгмийн солилцооны авилгал багасах, тэгсэнээр шүүхийн бие даасан, хараат бус байдал дээшлэх юм. Харин Монголын Үндсэн хуулийн эрх зүйн мэргэжилтнүүд одоогийн Үндсэн хуулийн тогтолцоонд ийм журам нийцэх эсэх эс бөгөөс Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодруулна биз ээ.

---

<sup>29</sup> ННФ-ын [www.forum.mn](http://www.forum.mn) портал сайтаас харах боломжтой

<sup>30</sup> Шүүгчид магадлан итэмжлэгдсэн сургууль төгссөн байвал бүр сайн. Гэтэл Монголд одоо хуулийн сургуулиудыг магадлан итгэмжлэлд оруулдаг систем байхгүй байгаа нь чанарын шаардлага хангахгүй олон сургууль байгуулагдах шалтгаан болж байна. Шүүхийн шинэтгэлтэй шууд холбоогүй ч гэсэн Монгол хуулийн сургуулийг магадлан итгэмжилдэг болох хэрэгтэй.

4. Шүүгч сайн ажиллах хөшүүрэг бий болгохын тулд анхан шатны шүүхээс давж заалдах шатны шүүхэд дэвшин ажиллах, шүүгчийн цалингийн нэмэгдэл зэрэг нь тухайн шүүгчийн хөдөлмөр зүтгэлийг харгалзан үзсэний үндсэн дээр шийддэг байх. Жишээ нь, Шүүхийн ажлын үнэлгээгээр авсан оноог үндэслэн албан тушаал ахих, цалин нэмэх арга хэмжээ авч байх.
5. Шүүгчид ажилд томилогдохоос өмнө нэлээн сайн сургалтад хамрагдсан байх. Сургалтын хөтөлбөрт шүүгчийн ёс зүйн дүрэм, нотолгооны журам, хууль зүйн үндэслэгээ, шийдвэр бичих, шүүгчийн нийгэм дэх үүрэг, материаллаг болон процессийн гол хууль зэрэг сэдвээр хичээл орсон байх.
6. Жил бүр шүүгч доод тал нь 20 цагийн үргэлжилсэн сургалтад хамрагдсан байх.

## ШҮҮХИЙН НЭР ХҮНД, БИЕ ДААСАН БАЙДАЛД ЧИГЛЭСЭН ШИНЭТГЭЛ

1. Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, зөвхөн Дээд шүүх эсвэл Үндсэн хуулийн Цэц (Үндсэн хуулийн асуудлаарх тохиолдол дээр) өмнө нь гаргасан тайлбар буруу байсан эсэхийг шийдэх эрхтэй байх. Дээд шүүхийн шийдвэр хуульд харшилж байгаа эсэхээс үл хамааран төрийн байгууллагууд түүний шийдвэрийг дагаж мөрддөг байх.
2. Шүүгчийн цалинг 1000-аас 3000 долларын хооронд тогтоож, энэ хооронд тухайн шүүгчийн цалинг хөдөлмөр зүтгэлээр нь тогтоож байх. Хуулиар шүүгчийн цалинг зүй бус үйлдэл гаргасан үндэслэлээр үндсэн цалинг нь тогтоосон хэмжээнээс бууруулахаас бусад ямар ч тохиолдолд багасгахгүй байх. Одоогийн цалингийн хэмжээг ингэж их хэмжээгээр нэмэгдүүлэх үндэслэл нь шүүгчийн цалин хамгийн шилдэг хүмүүсийг татахуйц байх, шүүгч авилгалд автан, ажлаа алдах эрсдэлд орохоос цааргалахуйц байх ёстой гэсэн эрх зүйн өөдрөг сэтгэлгээнээс үүдэлтэй юм. Цалин нь мөн хэрэг сайн шийдэж байх хөшүүрэг болох ёстой. Гэхдээ шүүхийн байгууллага авлигыг үл тэвчих бодлого баримталж, шүүхийн ил тод байдал, хариуцлагын тодорхой механизмыг бий болгохоос өмнө цалинг дээр санал болгосноор нэмэгдүүлж болохгүй.
3. Шүүхийн төсвийг улсын төсвийн тодорхой хувиар (2-оос 3 хувь байвал нэн сайн) тогтоож, тогтвортой болгох. Ингэснээр шүүхийн төсвийг буруугаар ашиглан тэдгээрт хяналтаа тогтоох явдлаас хамгаалагдана.
4. Шүүгчийг ажлаас чөлөөлөх журмыг маш тодорхой болгох хэрэгтэй. Зөвхөн тов тодорхой, албан ёсоор заасан зөрчил үйлдсэнийх нь төлөө ил тод журмаар бодит шалгуурт үндэслэн ажлаас чөлөөлөх буюу шийтгэх нөхцөлийг баталгаажуулах хэрэгтэй.

## ИЛ ТОД БАЙДАЛ РУУ ЧИГЛЭСЭН ШИНЭТГЭЛ

1. Шүүгчдэд хэрэг хуваарилахдаа сугалаа сугалуулах зэргээр ил тод арга боловсруулж мөрдөх. Тухайн шүүгчид нэгэнт хуваарилагдсан хэргийг ашиг сонирхлын зөрчил үүссэн зэрэг ноцтой үндэслэлээс бусад тохиолдолд өөр шүүгчид шилжүүлэхгүй байх хатуу журамтай байх.
2. Шүүхийн танхим бүрийн гадна талд тухайн хэрэгт ямар нэг байдлаар холбогдсон эсэхээс үл хамааран олон нийт шүүх хуралдаанд сууж болно гэдгийг тайлбарлан бичиж мэдээлж байх. Шүүгч, түүний туслах нар шүүх хуралдаан нээлттэй байх зарчмыг зөрчсөн тохиолдолд тэдний үйлдлийг буруушаан анхааруулж байвал зохино.
3. Анхан шатны шүүх нь шийдвэртээ тухайн хэргийн болсон баримт болон түүнд хэрэглэсэн хуулийн зүйл, заалт, шийдвэрийн үндэслэгээг бичгээр тайлбарласан байх үүргийг хуулиар тогтоож өгөх.
4. Шүүхийн бүх шийдвэр, баримт бичигтэй олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллага өдөр бүр, чөлөөтэй танилцах боломжийг тухайн шүүхийн байранд бий болгож, өдөр тутмын үйл ажиллагаандаа мониторинг хийх нөхцлийг бүрдүүлсэн байвал зохино.<sup>31</sup>
5. Шүүх хуралдааны тэмдэглэлийг нэг бүрчлэн хөтөлж байвал зохино. Тэмдэглэлийг хэргийн зохигч болон хэн боловч боломжийн төлбөртэйгээр авч болдог байхын зэрэгцээ давж заалдах гомдол гаргах хүсэлтэй ядуу иргэдэд үнэ төлбөргүй олгодог байх нь зохимжтой.
6. Анхан шатны болон давж заалдах, дээд шүүхийн бүх шийдвэрийг нэгтгэн, хэвлэн нийтлэх зорилготой албан ёсны мэдээллийн систем нэвтрүүлэх. Мэдээллийн систем нь электрон хэлбэрт оруулсан, онлайн үйлчилгээ үзүүлдэг байвал сайн бөгөөд хэрэв ингэж чадвал хүртээмж нь өргөжиж, зардал буурахаас гадна мэдээллийг цаг алдахгүй хүргэх боломж бүрдэнэ. Мөн түүнчлэн Улаанбаатар хотод байрлах Хууль зүйн үндэсний төв болон аймаг, сум бүрт аль нэг тохиромжтой газар өмгөөлөгч төдийгүй жирийн иргэд компьютерээс шууд мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх.
7. Шүүхийн шатанд байгаа хэргийн явцын талаарх мэдээлэл иргэдийн хэрэгцээг хангахуйц байдлаар нээлттэй байвал зохино. Ийм төрлийн мэдээллийг “хэргийн танилцуулах хуудас” хэлбэрээр олгож болох ба түүнд шүүхэд ирүүлсэн бүх баримт бичгийн нэр, огноо, захирамж, тогтоол зэргээс гадна шүүхээс хийсэн ажиллагаа, цаашид болох шүүх хурлын тов, хуулиар тогтоосон эцсийн хугацаа зэргийг жагсаан оруулсан байвал зохино. Эдгээр мэдээллийг шүүхийн байранд байрлуулсан компьютерээс нийтэд хүргэх төдийгүй онлайн захиалгын системээр дамжуулан авч болдог байвал зохино.

---

<sup>31</sup> Шүүхийн бүртгэл, шийдвэр зэргийг хэвлэлийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, бусад иргэд авах боломжийг бүрдүүлэхийн тулд олшруулан хэвлэх машин байрлуулах хэрэгтэй. Шүүхийн үйл ажиллагааг мэдээлэх ажилтнууд нь өдөр бүр шүүхийн мэдээлэл нээлттэй байгаа эсэхэд хяналт тавидаг байх нь зүйтэй.

8. Шүүхээс иргэдийг хуралд оруулахгүй байх, зохих журам дүрэм мөрдөгдөж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор шүүхийн ажиглагч ажиллуулах хөтөлбөр хэрэгжүүлбэл зохино. Ажиглагч үүнээс гадна шүүгчдийн шударга байдал, зан авир, мэргэжлийн ур чадварт үнэлгээ өгдөг байх нь зүйтэй. Отгонтэнгэр Их Сургуулийн хуулийн оюутнуудын Шүүхийн ажиглагч хөтөлбөрийг дахин сэргээж энэ зорилгоор ашиглаж болох юм.
9. Давж заалдах шатанд хэргийг дахин хянан шийдвэрлэдэг практикийг халах хэрэгтэй. Харин давж заалдах шатанд анхан шатны шүүх хурлын тэмдэглэлд үлдсэн баримтыг үндэслэн зөвхөн хууль хэрэглэхэд гаргасан алдаа болон хэргийн болсон баримтыг илэрхий гуйвуулсан тохиолдолд хэргийг хүлээж авдаг байвал зохино.
10. Нотолгооны нийтлэг хэм хэмжээ батлан гаргаж, тусад нь нэг багц болгон нийтлэх хэрэгтэй. Нотолгооны эдгээр хэм хэмжээ нь материаллаг эрх зүйд бүхэлд нь хамаатай бөгөөд бүх төрлийн шүүх ажиллагаанд хэрэглэгддэг байвал зохино.
11. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх нэгдсэн хууль гаргаж тусад нь нийтлэх. Энэхүү хууль нь бүх төрлийн иргэний маргаанд хэрэглэгддэг нийтлэг бүтэцтэй байх.
12. Анхан шатны шүүх хурал дуусмагц шүүхээр үйлчлүүлэгч бүх иргэдэд тэдний давж заалдах эрх, давж заалдах гомдол гаргах шат дараалал, эцсийн хугацаа зэргийг багтаасан ойлгоход хялбар гарын авлага тарааж өгдөг байвал зохино. Уг гарын авлагад мөн анхан шатны шүүхийн бичмэл шийдвэрийн хувийг иргэд авах эрхтэй, хэрэв төлбөр төлөх чадваргүй бол, анхан шатны шүүх хуралдааны тэмдэглэлийн хувийг үнэ төлбөргүй авах эрхтэй зэргийг дурдах хэрэгтэй.

## ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООГ ШИНЭЧЛЭХ ТАЛААР

1. Шүүгчийн ёс зүйн зөрчлийг мөрдөн шалгадаг тусгай байгууллага бий болгох юмуу эсвэл одоо байгаа Шүүхийн сахилгын хороог өөрчлөн байгуулах хэрэгтэй. Тус хорооны бүрэлдэхүүнд нэг ч шүүгч байж болохгүй. Хорооны дарга нь ч гэсэн одоогийнх шиг Дээд шүүхийн шүүгч байж таарахгүй. Хорооны гишүүдийг улс төрийн албан тушаалтан томилдог биш харин төрийн албаны шалгалт юмуу эсвэл өөр ямар нэгэн бодитой шалгуураар сонгон шалгаруулдаг байх нь зүйтэй. Хороо нь мөрдөн шалгах болон дуудан ирүүлэх эрх мэдэлтэй байхын зэрэгцээ мөрдөн шалгах, тухайлбал, тагнан шалгах ажлыг гүйцэтгэх материаллаг баазтай байх хэрэгтэй.
2. Шүүгчийн зөрчлийг мөрдөн шалгахдаа зохих ёсоор, нэг мөр зарчим баримтлан ажиллаж байга эсэхэд нь хяналт тавих зорилгоор Сахилгын хороонд хөндлөнгийн шалгалт хийдэг байх. Шалгалтын дүнг нийтэд мэдээлэх.

3. Шүүгчийг мөрдөн шалгаж, сахилгын шийтгэл оногдуулах дүрэм журмыг олон улсын шилдэг практикт үндэслэн өөрчлөн сайжруулах. Ингэхдээ сахилгын арга хэмжээ авах процесс хатуу стандарт бүхий ил тод, шударга байх. Нотолгооны стандарт нь хэт өндөрөөс болж шүүгчийн зүй бус үйлдлийг тогтоох боломжгүй байж болохгүй. Зүй бус үйлдэл гаргасан шүүгчийг нийтэд зарлах. Авлигад оролцсон байвал журмын дагуу ял шийтгэл ногдуулах.
4. Шүүгчийн ёс зүйн дүрмийг олон улсын шилдэг стандартад нийцүүлэн өөрчлөх буюу дор хаяж дараах өөрчлөлтийг хийх хэрэгтэй:
  - Хэргийн талууд тэдний өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзахыг хориглох
  - Дээд шатны юмуу ахлах шүүгч нь доод шатны шүүхийн шүүгчтэй шийдэх гэж байгаа хэрэг маргааны талаар ярьж хэлэлцэхийг хориглох.
  - Тухайн хэрэгт ах дүү, төрөл садан нь холбоотой тохиолдолд шүүгчийг хэрэг шүүхийг хориглох.
  - Шүүгч өөрийн ажлаас гадна өөр ажил хавсрах, бизнес эрхлэхийг хориглох.
  - Ашиг сонирхлын зөрчлийг тов тодорхой зааж, ашиг сонирхлын зөрчил илт байгаа буюу байж болох хардалт байгаа үед тухайн шүүгчийг хэрэг шийдэхийг нь хориглох.
  - Хувь хүн, төрийн албан тушаалтан хэн боловч шүүгчтэй хэргийн талаар ярьж, хэлэлцэхийг хориглох
5. Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж өгөхийг хатуу шаардах, хууль ёсны бүх орлого, хөрөнгөө баримтжуулах үүргийг шүүгчид ногдуулах.
6. Урьд өмнө шүүгч, прокурор, өмгөөлөгч байсан эсвэл одоо ч байгаа бүх ах дүү төрөл садныхаа нэрийг гаргаж өгөхийг шүүгчээс шаардах.
7. Шүүхийн байгууллагад ажиллагсдын гэр бүл садан төрлийн холбоог харуулсан баримт гаргуулж, ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдлыг хянах.

## АВЛИГААС СЭРГИЙЛЭХ ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭ

1. Хүнд, онц хүнд гэмт хэрэг, мөн 10 сая төгрөгөөс дээш мөнгөн дүн бүхий иргэний хэрэгт тангарагтны шүүх хэрэглэдэг болох. Хэрэг, маргааны талаарх эцсийн шийдвэр гаргах эрхийг ганц шүүгч эдэлдэг тогтолцоог халж, уг эрхийг тангарагтны шүүхэд өгөх нь авлигаас сэргийлэх нэлээн үр дүнтэй арга болно. Ганц шүүгч авлигад автах нь илүү амархан байдгийг анхаарах. Тангарагтны шүүх нь шүүх хуралдаан эхлэх хүртэл бүрэлдэхүүнд нь хэдэн хүн байгаа, ямар хүмүүс байгаа нь тодорхойгүй



байдгаараа амархан нөлөөнд автах, худалдагдах явдлаас сэргүүлдэг учраас үр дүнтэй байдгийг судалгаа харуулж байна.<sup>32</sup>

